

“Үйл явдал” НОМ

3-р хичээл

Гол сэдвүүд

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2012 by Гурав дахь мянган үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Энэхүү материалыг 2007 онд Ийгли ТВ-н Христийн Нэвтрүүлгийн албанд орчуулсан бөгөөд Библийн зарим эшлэлүүдийг Монголын Библийн Нийгэмлэгийн Шинэ Гэрээ©1990 номноос зохиогчийн зүгээс Ийгл ТВ-ын Христийн нэвтрүүлгийн албанд өгсөн зөвшөөрлийн дагуу оруулсан. Библийн бусад эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи ©2004-ээс авлаа.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

дахь мянган үйлчлэл нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчлэл бөгөөд дараах талбаруудад чиглэдэг:

Библийн боловсролыг. Бүх дэлхийд. Үнэгүй.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид теологийн мэргэжлийн сургагч багш нар байдаг бөгөөд орчуулагчид нь орон нутгийнхаа унаган хэлтэй теологийн мэдлэгтэй хүмүүс байдгаараа давуу талтай. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.thirdmill.org цахим хуудсаар зочлоорой.

“Үйл явдал” ном

Гуравдугаар хичээл

НОМЫН ГОЛ СЭДВҮҮД

Агуулга

УДИРТГАЛ	1
Ариун Сүнс	1
Пэнтээхөст баярын өмнө	2
Цаг хугацааны сонголт	2
Зорилго	4
Пэнтээхөст баярын өдөр	5
Утга учир	6
Үл мэдэх хэл	7
Үр дүн	9
Пэнтээхөст баярын дараа	9
Шомрон аймаг	11
Цезаре хот	12
Эфэс хот	13
Төлөөлөгчид	14
Хосгүй	15
тавигдах шаардлага	15
суурийг тавих үе	16
Эрх мэдэлтэй	17
Үйл ажиллагаа	17
Ивээл	19
Гайхамшигт үйлс	19
Илчлэлт	20
Олон янз	21
Стратеги	21
Орчин	23
Сүм	24
Зайлшгүй шаардлагатай байдал	24
Бие махбодын хязгаарлагдмал байдал	25
Цаг хугацааны хязгаарлагдмал байдал	25
Бэлтгэл	26
Сургаал	27
Албан тушаалтан	28
Бэрхшээл саад	30
ДҮГНЭЛТ	31
ТАЙЛБАР ТОЛЬ	33

“Үйл явдал” ном

Гуравдугаар хичээл

номын гол сэдвүүд

УДИРТГАЛ

Бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн дэргэд байсан хэн боловч эцэг эхчүүд нь хүүхдүүддээ аливаа зааврыг дахин дахин хэлдэг гэдгийг мэднэ. Эцэг эхчүүд хүүхдүүдээ ухаан сууж төлөвшихөд нь тусалж, үр бүтээлтэй амьдралд бэлтгэхийн тулд нэг л санааг олон удаа давтан хэлдэг.

Яг үүнтэй адил бид Үйл явдал номыг уншиж байхдаа Луух зарим нэг сэдвийн талаар олон удаа дурьдаж байгаа нь бидэнд тодорхой мэдрэгддэг билээ. Иймэрхүү дахин дахин давтагдсан гол санаа Луухын энэ номыг турш гардаг бөгөөд түүний сургаалийг ойлгох тун чухал түлхүүр болдог юм. Тийм учраас бид Үйл явдал номын утга учрыг ойлгохыг хүсэж байгаа бол иймэрхүү дахин дахин давтагдан гарах сэдвийг маш их анхаарах хэрэгтэй.

Энэ бол “Үйл явдал” номоор зааж буй цуврал хичээлийн маань гуравдахь нь юм. Бид энэ хичээлийг “Гол сэдвүүд” гэж нэрлэлээ. Бид энэ хичээлээр эхэн үеийн итгэгчид Ертөнцийн Эзэний хаант улсын тухай өгүүлсэн хэн ч саад хийж үл чадах сайн мэдээг тарааж байгааг дэлгэхдээ Луухын дахин дахин дурдсан гурван гол санааг судлах болно.

Өмнөх хичээлүүдэд бид, “Луух бол Сайн мэдээний асар хүчтэй нөлөөний тухай өгүүлсэн түүхэн тэмдэглэл бичсэн юм” хэмээн Үйл явдал номонд өгүүлсэн түүний зорилгыг хураангуйлсан билээ. Луух түүхэн баримтуудыг Ариун Сүнсээр дамжуулан хийсэн Христийн тасралтгүй үргэлжилэх ажлын найдаж болох гэрчлэл болгож бичсэнийг бид харсан. Харин бид энэ хичээлээр дээрх зорилгыг нарийвлан үзэхдээ гол санаагаа хамгаалж дүрслэн харуулахын тулд Луухын ашигласан зарим нэг чухал сэдвийг гүнзгий үзэх болно.

Бид Үйл явдал номын эхлэл хэсэгт танилцуулж, улмаар бүх бүлгийн турш хөгжиж бүрэн дүр төрхөө олсон гурван гол сэдвийг үзнэ. Нэгдүгээрт, бид Христийн хаант улсыг өргөжүүлэхийн тулд итгэгчидэд бүрэн эрх олгосон Ариун Сүнс гэсэн сэдвийг үзнэ. Хоёрдугаарт, бид Христийг бусдад гэрчилж, Түүний сүмд үйлчилж тэднийг удирдах бүрэн эрхтэй байхаар Ертөнцийн Эзэний дуудсан эрчүүд болох Төлөөлөгчдөд анхаарлаа хандуулна. Гуравдугаарт, бид Христийн тухай сайн мэдээ болон Ертөнцийн Эзэний хаант улсыг түүхийн туршид үргэлжлүүлэн найдвартай дэлгэрүүлэхийн тулд Есүсийн төлөөлөгчдийн байгуулсан сүмийн тухай сэдвийг авч үзнэ. За одоо бүгдээрээ эхлээд Үйл явдал номонд Ариун Сүнс болон Түүний гүйцэтгэх үүргийн талаар хэрхэн өгүүлсэнийг үзэцгээе.

АРИУН СҮНС

Үйл явдал ном нь Ариун Сүнсний теологийн талаар ихийг танилцуулдаг.

Энэ нь Түүнийг Христэд итгэгчдэд хувиран өөрчлөгдсөн амьдралаар амьдарч дэлхий даяар авралын зар тараах эрх мэдлийг өгөгч гэж тодорхойлосон байдаг. Тэрбээр Есүсийн төлөөлөгчид болон эхэн үеийн сүмийн удирдагчдын үйлчлэлийг хүчин төгөлдөр болгохын тулд маш олон гайхамшгийг бүтээсэн гэдгийг энэ номонд бичиж тэмдэглэжээ. Мөн Ариун Сүнс нь эсэргүүцэл тэмцэл, хавчлага зовлонтой тулгарсан Христэд итгэгчдэд маш их урам зориг өгсөнийг нотлон харуулсан байдаг. Товчхон хэлэхэд, Үйл явдал номонд Ариун Сүнсийг сайн мэдээ болон ер бусын хаант улсыг түгэн дэлгэрэх хүчийг өгөгч, мөн Өөрийн хүмүүст ариун амьдрахад нь дэмжлэг үзүүлэгч гэж тодорхойлжээ.

Хэдийгээр Үйл явдал номонд Ариун Сүнс нь олон янзын аргаар ажилласан байдаг ч бид цаг хугацааны гурван өөр үед сүмд үзүүлсэн Түүний нөлөөнд анхаарлаа голлон хандуулах болно. Нэгдүгээрт, бид Үйл явдал номонд бичсэн Ариун Сүнсийг Пэнтээхөст баярын өмнө ямар байсан талаар үзнэ. Хоёрдугаарт, бид Пэнтээхөст баярын үеэр Иерусалим хотод Ариун Сүнс цутган буусан талаар шинжлэн судлана. Харин гуравдугаарт, бид Пэнтээхөст баярын өдрийн дараа Ариун Сүнсний үйлдсэн ажил үйлсийг судлах болно. Одоо бүгдээрээ Үйл явдал номонд Пэнтөөхөст баярын өмнөх Ариун Сүнсийг хэрхэн дүрсэлснийг үзэцгээе.

ПЭНТЭЭХӨСТ БАЯРЫН ӨМНӨ

Үйл явдал номын 1-р бүлгийн 3-аас 11-д Есүс дахин амилчихаад тэнгэрт одох хүртлээ өөрийн сонгосон төлөөлөгчдөд 40 гаруй хоног сургаал заасан гэж тэмдэглэсэн байдаг. Бид Үйл явдлын 1-р бүлгийн 3-т:

[Есүс] дөчин хоногийн дотор төлөөлөгчдийнхөө өмнө олон удаа үзэгдэж . . . тэдэнд Ертөнцийн Эзэний хаант улсын тухай ярих (Үйл явдал 1:3).

Ер бусын хаант улсын тухай Есүсийн сургаалийн нэг чухал хэсэг нь Төлөөлөгчдөд Ариун Сүнс онцгой байдлаар ирэх тухай өгүүлдгийг бид удахгүй харна.

Бид Пэнтээхөст баярын өмнөх Ариун Сүнсний тухай өгүүлсэн Есүсийн сургаалийн хоёр талыг хөндөнө. Эхлээд бид Ариун Сүнс ирэх цаг хугацааны сонголтын талаар үзнэ. Хоёрдугаарт бид Түүний ирсэн зорилгыг голлож үзнэ. За эхлээд бүгдээрээ Ариун Сүнс ирэх цаг хугацааны сонголтын талаар Есүсийн заасан сургаалыг анхааран үзэцгээе.

Цаг хугацааны сонголт

Үйл явдал номын 1-р бүлгийн 4-өөс 8-д буй Есүсийн үгийг сонсоцгооё. Тэнд ингэж бичжээ:

“. . . Ертөнцийн Эзэн та нарыг өөрийнхөө Ариун Сүнстэй болгон баталж өгнө. Тийм учраас Иерусалим хотоос явалгүй түр байж,

Ертөнцийн Эзний амласан тэр баталгааг хүлээгтүн!” . . . Төлөөлөгчид нь Есүстэй уулзахдаа, “Их Эзэн минь ээ! Одоо та Израйлийг Ромын хаант улсаас чөлөөлж, дахин биеэ даасан Израйль улсыг байгуулах уу?” гэж асуухад, “Ертөнцийн Эзэн-Эцгээс минь өөр хэн ч тэр үеийг тогтоохгүй. . . Харин түүний Ариун Сүнс та нартай нэгдэн асар их хүч чадал өгч Иерусалим хот, Иудей, Шомрон аймаг байтугай энэ дэлхийн өнцөг булан бүрт илгээн, миний тухай яриулах болно” гэж Есүс хэлэв (Үйл явдал 1:4-8).

Ариун Сүнс ирж тэднийг батлах тухай Есүсийг мэдэгдэж байх үед Төлөөлөгчид Түүнээс дахин биеэ даасан Израйль улсыг байгуулах тухай асууж байгааг анхаараарай. Энэ Израйлийн хаант улсыг дахин сэргээх гэдэг ойлголт орчин үеийн олон уншигчдад төдийлөн танил бус учраас үүнийг эхлээд тайлбарлая.

Израйль болон Иудейчүүдын хийсэн гэм асар их болсон учраас Ертөнцийн Эзэн тэднийг Амласан нутгаас гаргаж харийн харгис хэрцгий дарангуйлагчдын эрхшээлд оруулж цөлөх тухай Хуучин Гэрээний зөнчид зөгнөжээ. Иудейчүүд Хуучин Гэрээний иймэрхүү зөгнөл дээр үндэслээд Ертөнцийн Эзэн хожим тэдний гэмийг уучилж, эх нутаг уруу нь буцааж, улмаар удирдан захирах Аврагчийг илгээнэ хэмээн итгэх болжээ. Давидын удмаас төрөх тэр Аврагч нь Израйль болон Иудейн хаан болох бөгөөд Амласан нутгийг Ертөнцийн Эзний хүмүүсийн үүрд мөнх аз жаргалтай амьдрах Түүний хаант улсын төв болгох ажээ. Харин 1-р зууны үеийн Израйль орон олон зуун жил дээрх шийтгэлээс болж зовж зүдэрсний улмаас улс төрийн хувьд Израйлийн хаант улсыг дахин сэргээх Аврагчийг тун их хүсэмжлэн хүлээж байлаа. Тийм учраас Есүсийг тэнгэрт одох тухай олж мэдсэн Төлөөлөгчид нь Түүнийг явахаасаа өмнө Хуучин Гэрээний дээрх зөгнөлийг биелүүлэх байх гэж найдаж байв. Тэд яагаад Түүнээс Израйлийн хаант улсыг дахин сэргээх талаар асуугаад байсан нь ийм учиртай юм. Гэвч Израйль орон улс төрийн хувьд гэнэт дахин сэргэх тухай олон түмний энэ горьдлого буруу бөгөөд Сайн мэдээ дэлхий даяар тарж Христ яруу алдраа дуурсган эргэж ирэх үйл явц л Хуучин Гэрээний иймэрхүү зөгнөлийг Ертөнцийн Эзэн биелүүлж байгаа явдал гэдгийг Есүс тэдэнд заасан байна.

Харин яагаад Ариун Сүнс ирж тэднийг батлах тухай Есүсийг ярьсаар байтал Төлөөлөгчид нь Түүнээс Израйлийн хаант улсыг дахин сэргээх талаар асуугаад байсан юм бол? Төлөөлөгчид Хуучин Гэрээний зөгнөлийн талаар бодсоор л байжээ. Гэхдээ Хуучин Гэрээний нэлээд хэдэн хэсэгт шүүлт өнгөрсний дараа Ертөнцийн Эзэн Сүнсээ урд өмнө үзэгдэж харагдаж байгаагүйгээр ихээр асгана хэмээн зөнчид урьдчилан хэлсэн байдаг. Ариун Сүнсний тухай зөнч Исаиа юу гэж хэлснийг сонсоцгооё. Исаиа номын 44-р бүлгийн 3-аас 4-д:

Би ангамал хөрсөн дээр ус асгаж, хуурай газар дээр горхи урсгана. Би чиний үр ач нарын дээр Сүнсээ асгаж, хойч үед чинь ерөөлөө буулгана. Тэд нугын өвс шиг, усны урсгалын хажуу дахь улиангар мэт ургана (Исаиа 44:3-4).

Энд Исаиа Ертөнцийн Эзэн тэр нутагт Сүнсээ буулгаж дахин сэргээх тухай өгүүлжээ.

Израильчууд Еврей багш нар болох Рабичуудын “гэм, завхрал, үхлээр дүүрсэн энэ эрин үе” гэж нэрлэсэн тийм үед амьдрах болно хэмээн энэ Аврагчийг ирэхээс өмнө Хуучин Гэрээний зөнчид тунхагласан байдаг. Мөн тэд Аврагч ирээд “Ирж байгаа үе” гэж Раби багш нарыг нэрлэсэн шинэ үеийг эхлүүлэх бөгөөд тэр үед Ертөнцийн Эзэний дайснууд гэм буруугаа шүүлгэж, харин Түүний хүмүүс нэгмөсөн эргэлт буцалтгүй ивээгдэх болно хэмээн тунхаглаж байлаа. Хуучин Гэрээний зөнчид энэ үйл явц хэдий хугацаанд болохыг нарийн тайлбарлаагүй боловч, Еврейн ихэнх Раби багш нар үүнийг бүгд нэг агшинд болно гэж үзэж байв.

Есүс энэ үзэл бодолтой сөргүүлэн, Ертөнцийн Эзэний хаант улс нь цаг хугацаа өнгөрөх бүр улс үндэстнүүдийн дунд байгуулагдах тухай тайлбарласан. Бүх зүйл агшин зуур болж өнгөрөхийн оронд Түүний яруу алдарт хаант улс нь үе шаттайгаар байгуулагдах ажээ. Энэ шинэ үе нь Есүсийн газар дэлхий дээрх үйлчлэлийн үеэр албан ёсоор эхэлсэн юм. Энэ хаант улс өргөжин тэлэх явдал Есүсийг мөнхийн жаргалтай улсдаа хаанчилж байх үед ч Сайн мэдээгээр дамжин үргэлжилсээр л байна. Харин ирээдүйд Есүсийг эргэж ирэхэд гэмд автагдсан энэ эрин үе бүрэн эцэс болж Аврагчийн бүх дэлхийг хамарсан хаант улс байгуулах ажил дуусч төгсгөлийнхээ шатанд орох болно.

Ер бусын хаант улс удахгүй байгуулагдах тухай энэ үзэл бодол нь яагаад Есүс төлөөлөгчдийнхөө асуултад тэгж хариулсаныг тайлбарлаж байна. Христэд итгэгчдийн дээр Ариун Сүнс цутган буусан явдал нь Түүний хаант улс агшин зуур байгуулагдана гэсэн утгатай биш ээ. Зөвхөн Есүс л энэ хаант улсыг эхлүүлсэн бөгөөд Өөрийг нь дахин ирэх хүртэл итгэгчдийг гэмт хорвоод амьдарч байх үед нь хэрэгцээтэй бүхнээр хангах гэж л тэднийг Ариун Сүнсээр ивээсэн юм. Нэгэнт л Ариун Сүнс ирэх цаг хугацааны сонголтын талаар мэдэж авсан тул одоо Түүний ирэх болсон зорилгын тухай үзэцгээе.

Зорилго

Бүгдээрээ Үйл явдал номын 1-ийн 8-д буй төлөөлөгчдөдөө хандаж хэлсэн Есүсийн үгийг дахин нэг сонсоцгооё. Тэнд:

Харин түүний Ариун Сүнс та нартай нэгдэн асар их хүч чадал өгч Иерусалим хот, Иудей, Шомрон аймаг байтугай энэ дэлхийн өнцөг булан бүрт илгээн, миний тухай яриулах болно_(Үйл явдал 1:8).

Өөрөөр хэлбэл, Есүс төлөөлөгчдөө Ариун Сүнсний баталгааны талаар цоо шинээр бодож үзэхэд хүргэсэн. Энэ ер бусын хаант улсын сүүлчийн үеийг нээхийн оронд, Христийн найдвартай итгэлтэй гэрч болсон төлөөлөгчдийг эрх мэдэлтэй болгохын тулд Ариун Сүнс цутгасан бууж ирсэн юм. Ариун Сүнсний үйлчлэлийн хоёр тал болсон хүч чадал ба Ертөнцийн Эзэнийг таниулсан гэрчлэл дээр гол анхаарлаа хандуулан Есүсийн хэлсэн үгийн утгыг тайлцгаая.

Нэгдүгээрт, дагалдагчид нь Ариун Сүнсний баталгаа хүртэхдээ асар их хүч чадалтай болно гэж Есүс хэлсэн. Ариун Сүнсний дагалдаж хүч чадал хамт явдаг гэсэн санаа Хуучин Гэрээнд их нийтлэг байв. Үүнийг ихэвчлэн Еврей хэлээр “руах Элохим” буюу “Ертөнцийн Эзэний Сүнс” гэдэг үгээр илэрхийлдэг. Энэ Еврей үг нь Ертөнцийн Эзэнээс ирсэн асар хүчтэй салхи буюу эрч хүч гэсэн санааг илэрхийлдэг

байна. Хуучин Гэрээний үед Ертөнцийн Эзэний Сүнс нь гол төлөв Түүний хүслийг дамжуулахын тулд дэлхий дээр маш хүчтэй ажилладаг байлаа.

Мөн Ариун Сүнсний хүч чадал нь хүмүүсийн амьдралд ч гэсэн мэдэгдэхүйц байдлаар илрэн харагддаг байсан. Жишээлбэл, “Шүүгчид” номын 14, 15-р бүлэгт өгүүлсэнээр бол Ертөнцийн Эзэний Сүнс Самсон дээр ирэхэд тэрбээр биеийн хүч чадлаар гайхалтай гавъяа байгуулж Филистчүүдийг ялж Израйльчуудад ялалт авчирсан тухай гардаг билээ.

Есүс Ариун Сүнсний хүч чадлаас гадна энэ Сүнс дагалдагчдыг нь Ертөнцийн Эзэнийг бусдад таниулсан гэрчлэл хийхэд хүргэдэг гэсэн билээ. Хуучин Гэрээнд ийм гэрчлэлийн талаар бас өгүүлдэг. Нэлээд хэдэн хэсэгт Ертөнцийн Эзэний Сүнс нь Түүний өмнөөс зоригтой үр нөлөөтэй ярих хүч чадлыг хүмүүст өгсөн тухай дурджээ. Жишээлбэл Мика номын 3-р бүлгийн 8-д:

Харин миний хувьд бол би хүч чадлаар, Мөнхийн Эзэний Сүнсээр дүүрсэн (Мика 3:8).

Энэ хэсэгт Мика хэдийгээр түүнийг хуурамч зөнчид эсэргүүцэж байсан ч Мөнхийн Эзэний Сүнс түүнийг үнэнийг ярихад нь зоригжуулж байсан гэж тайлбарласан байна.

Есүс Өөрийнхөө тухай гэрчлэх эрх мэдэлтэй болгохын тулд Төлөөлөгчдөө Ариун Сүнсээр батлахдаа Хуучин Гэрээний үед бусдаар дамжуулан Ариун Сүнс ажлаа хийж байсантай адил, тэд ч бас тэгж ажиллана гэдгийг үзүүлсэн юм. Мөн Ариун Сүнс Есүсийн төлөөлөгчдийн тунхаглаж буй мэдээ үнэн гэдгийг батлахын тулд ер бусын хүчтэй үйлсийг бүтээж, тэднийг эсэргүүцэж буй хүмүүст хэлэх үгийг нь өгдөг байлаа. Мэдээж Ариун Сүнсний иймэрхүү үйлдэл Үйл явдал номонд дахин дахин гардаг.

Ийнхүү Луух Пэнтээхөст баярын өмнөх Ариун Сүнсний байдлыг хэрхэн танилцуулж байгааг бид харлаа. Одоо бүгдээрээ Христэд итгэгчдийг Пэнтээхөст баярын өдөр Иерусалим хотод цугларсан үед тэд нар дээр Ариун Сүнс хэрхэн цутган буусан тухай үзэцгээе.

ПЭНТЭЭХӨСТ БАЯРЫН ӨДӨР

Үйл явдал номын 2-р бүлгийн 1-ээс 4-т Христэд итгэгчид дээр Ариун Сүнс цутган буусан тухай ингэж өгүүлжээ:

Ертөнцийн Эзэний тогтоосон Пэнтээхөст гэдэг баярын өдөр Есүст итгэгчид цуглан хуралдаж байтал тэнгэрт ширүүн салхин мэт дуу чимээ гэнэт сонсогдон, орчныг эзлэн хүнгэнэв. Галын дөл мэт юм салбарлан хүн бүрт шүргэж, хүн бүр Ертөнцийн Эзэний Ариун Сүнс тэй болж, огт мэдэхгүй олон янзын хэлээр ярьж эхлэв (Үйл явдал 2:1-4).

Энэ явдлын ач холбогдлыг судлахын тулд бид гурван гол асуудлыг хөндөх болно. Эхлээд бид Пэнтээхөст баярын утга учрыг үзнэ. Дараа нь бид үл мэдэх хэлээр ярих гэгч гоц үзэгдлийн талаар авч үзнэ. Эцэст нь бид энэ бүх үйл явдлын

эцсийн үр дүнгийн талаар ярилцах болно. За эхлээд бүгдээрээ Пэнтээхөст баярын утга учрыг талаар үзэцгээе.

Утга учир

Пэнтээхөст гэдэг нь Израйльчуудын тэмдэглэдэг ариун нандин баярын нэг бөгөөд Дээгүүр өнгөрөх баяртай тун ойр холбоотой. “Чөлөөлөгдсөн нь” номын 12-р бүлэг, “Левит” номын 23-р бүлэгт бичсэнээр бол Дээгүүр өнгөрөх баяр бол Израйльчууд Египетээс чөлөөлөгдсөнөө санан дурсдаг үе ажээ. Энэ бол Еврейчүүдэд учруулсан Ертөнцийн Эзэний сүүлчийн гамшиг болох Египет айл бүрийн ууган хүүхдийг хөнөөж, харин Өөрт нь бат итгэдэг Израйль айлын дээгүүр өнгөрсөн тэр шөнийг дурсан тэмдэглэдэг үе юм. Дээгүүр өнгөрөх баяр нь Ертөнцийн Эзэн Еврейчүүдийг Египетийн боолчлолоос хэрхэн чөлөөлсөнийг тэдэнд сануулдаг.

Пэнтээхөст нь Дээгүүр өнгөрөх баярыг тэмдэглэснээс хойш 50 хоногийн дараа анхны ургац хураах үед болдог байв. Эхэндээ үүнийг Ертөнцийн Эзэн амласан нутагтаа тэднийг хоол хүнсээр элбэг дэлбэг хангаж байгааг талархан тэмдэглэдэг байлаа. Тэр үед Израйльчууд тухайн жилдээ хураах бүх ургацандаа баярлаж талархаж байгаагаа илэрхийлж анхны ургацынхаа дээжийг өргөл болгон өргөдөг байв.

Үүн дээр нэмж хэлэхэд Шинэ Гэрээний үед Иудейчүүд Пэнтээхөст баярыг тэмдэглэж байхдаа Мөшэхэд Ертөнцийн Эзэний Хуулийг өгсөн явдлыг бас санан дурсдаг байлаа. Эхэн үеийн итгэгчдэд яг энэ үед Ариун Сүнс бууж ирсэн нь тэдэнд зөнч Иеремиагийн тунхагласан найдварыг сануулж байсан учраас бас их утга учиртай байсан юм. Бүгдээрээ зөнч Иеремиа юу гэж хэлснийг түүний бичсэн номын 31-р бүлгийн 31-ээс 33-р ишлэлээс сонсоцгооё. Тэнд:

“Мөнхийн Эзэн ингэж тунхаглаж байна. ‘Би Израйлийн болон Иудейн гэр бүлтэй шинэ гэрээ байгуулна. . . Би өөрийн хуулиа тэдний оюун ухаанд хийж, зүрх сэтгэлд нь бичнэ. Би тэдний хүндлэн дээдлэх Ертөнцийн Эзэн нь болно. Харин тэд Миний ард түмэн болох тэр цаг удахгүй ирнэ” (Иеремиа 31:31-33).

Хуулийг зүрх сэтгэлд нь бичих гэдэг нь Хуучин Гэрээнд амласан Ертөнцийн Эзэний Сүнсний ажил бөгөөд Шинэ Гэрээний үед бүрэн биелэгдсэн юм.

Ертөнцийн Эзэний Сүнсний холбоотой Хуучин Гэрээний энэ амлалтыг сэтгэлдээ хадгалж байх нь Үйл явдал номын 2-р бүлэгт дурдсан Пэнтээхөст баярын өдөр Ариун Сүнс ирсэн явдал Христэд итгэгчдийн хувьд маш утга учиртай байв. Дээгүүр өнгөрөх баярыг тэмдэглэж байх үед Есүс загалмай дээр цовдлогдсон билээ. Тэрбээр Ертөнцийн Эзэний хүмүүсийг гэм болон үхлийн боолчлолоос мөнхөд чөлөөлөхийн тулд Дээгүүр өнгөрөх баярын эцсийн хурга болж амиа өгсөн юм. Үүнийг Пууль 1 Коринфын 5-ийн 7-д:

Бидний Дээгүүр өнгөрөх баярын хурга болж Есүс амиа золиосолсон юм (1 Коринф 5:7).

Энэ бүхнийг харгалзан үзвэл, Ертөнцийн Эзэний Сүнс Пэнтээхөст баярын өдөр цутган буусанд гайхах явдалгүй билээ. Пэнтээхөст баяр нь олон түмний анхаарлыг арвин ургац хураах үйлсэд хандуулж байх мөчид Ариун Сүнс ирсэн нь мөнхийн авралын ургацын дээж болсон. Христэд итгэгчдийн оролцож байсан анхны Пэнтээхөст баярын өдөр Ариун Сүнс ирсэн нь тэдний зүрх сэтгэлд Ертөнцийн Эзэний хуулийг оруулж, Түүний тухай зоригтой гэрчлэхэд шаардагдах бүхнээр хангаж өгөв. Тийм учраас Ромын 8-р бүлгийн 23-д Пуулийн хэлсэнчлэн

Христэд итгэгчид бол Ариун Сүнсний анхны үр жимс нь юм (Ром 8:23).

Ийнхүү Луух Ариун Сүнс цутган буусан тухай бичихдээ энэ болж өнгөрсөн бүхэн асар их утга учиртай байсныг харуулахын тулд Пэнтээхөст баяртай холбож онцолсон байна. Энэ бол жирийн нэг үйл явдал байсангүй. Түүгээр ч барахгүй олон гайхамшигийн нэг нь байгаагүй юм. Пэнтээхөст баярын өдөр Ариун Сүнснийг бэлэг болгон өгсөн явдал нь авралын агуу их ургац болон Ертөнцийн Эзэний аврагчийн удирдсан хаант улсыг байгуулах Түүний хүмүүсийг дотроос нь шинэчлэхийн эхлэл болсон юм.

Ийнхүү бид Пэнтээхөст баярын зарим нэг утга учрыг Ариун Сүнс ирсэн үетэй холбож ойлголоо. Одоо бүгдээрээ Ариун Сүнстэй болсоны илэрхийлэл болгож үл мэдэх хэлээр ярих гоц үзэгдлийн тухай үзэцгээе.

Үл мэдэх хэл

Луух Үйл явдал номын 2-р бүлэгт Пэнтээхөст баярын өдөр Есүст итгэдэг хүмүүст Ариун Сүнс ирсэний дараа төлөөлөгчид болон бусад дагалдагчид өөр хэл яриагаар ярьсан тухай бичсэн билээ. Харамсалтай нь Христэд итгэгчдийн дунд энэ үл мэдэх хэлээр ярих авьяасын талаар маш их буруу ойлголт байдаг. Тийм учраас бид үүнтэй холбоотой хоёр асуудлын талаар ярих шаардлагатай болж байна. Нэгдүгээрт, үл мэдэх хэлээр ярих авьяас гэгч юу болох талаар үзнэ. Хоёрдугаарт нь Ертөнцийн Эзэн яагаад ийм авьяасыг өгсөн талаар үзнэ.

Өнөөгийн сүм цуглаануудад буй Христэд итгэгчид энэ үл мэдэх хэлээр ярих авьяасыг янз бүрээр ойлгодог. Зарим нь үүнийг ярих бус сонсох гайхамшиг гэж үздэг. Ийм үзлээр бол Есүсийн төлөөлөгчид хөөрч догдолж ярьсан, харин Ариун Сүнс үүнийг сонсож байгаа хүмүүст өөрсдийн хэлээр ойлгох боломж өгсөн аж.

Гэхдээ энэ тухай бичсэн Луухын тодорхойлолт нь хоёр зүйлийг маш тодорхой харуулдаг юм. Эхнийх нь энэ бол ярихтай холбоотой гайхамшиг байсныг, удаах нь эхэн үеийн итгэгчид өөрсдийн сураагүй, энгийн хүмүүсийн ярьдаг тийм л хэлээр ярьсан болохыг харуулдаг. Хамгийн чухал нь Ариун Сүнс тэр хүмүүсийг өөр хэлээр яриулсан гэдгийг Луух онцгойлон бичсэн байдаг. Энэ тухай бид Үйл явдал номын 2-р бүлгийн 4-т:

Галын дөл мэт юм салбарлан хүн бүрт шүргэж, хүн бүр Ариун Сүнстэй болж, огт мэдэхгүй олон янзын хэлээр ярьж эхлэв (Үйл явдал 2:4).

Энэ үед Ариун Сүнс тэдэнд гайхалтай сонсох чадвар өгсөн тухай Луух огт дурдаагүй байна. Хоёрдугаарт, энд орсон “хэл” гэдэг үг нь Грек хэлний “глосса” гэдэг үгийн орчуулга юм. Шинэ Гэрээ болон Грекийн бусад утга зохиолд энгийн хэл яриаг ихэвчлэн энэ үгээр тэмдэглэдэг. Энэ үг нь тухайн хам сэдэвт ямар нэгэн өөр утгаар орсон гэж үзэж эргэлзэх хангалттай шалтгаан байдаггүй. Тийм учраас бид Пэнтээхөст баярын өдөр үл мэдэх хэлээр ярьсан гайхамшигтай явдал бол тэр хүмүүс ер бусын чадварын хүчээр өөрсдийн мэдэхгүй харь орны хэлээр ярьсан гэдэгт итгэлтэй байж болно.

Харин *яагаад* Ариун Сүнс өөрийн оршин байгааг ийм арга замаар илэрхийлсэн юм бол? Тухайн өдөр үл мэдэх хэлээр ярьсан нь ямар утга учиртай байв? Бүгдээрээ Үйл явдал номын 2-р бүлгийн 16-аас 21-д буй Пэтрийн тайлбарыг сонсоцгооё. Тэнд:

“Энэ эрин үе төгсөхөөс өмнө би Ариун Сүнсээ хүмүүст илгээнэ. Хүүхдүүд чинь миний үгийг дамжуулна. Залуучууд чинь ер бусын үзэгдэл үзнэ. Өвгөд чинь сонин хачин зүүд зүүдлэнэ. Надад итгэдэг эмэгтэй эрэгтэй бүх хүн миний үгийг ярих болно. . . Тэр үед надаас аврал гуйсан хүн бүрийг Их Эзэн би аврах болно” гэсэн үгийг Ертөнцийн Эзэн эрт цагт Иоелээр зөгнүүлжээ (Үйл явдал 2:16-21).

Энэ хэсэгт Пэтр Иоел номын 2-р бүлгийн 28-аас 32-ийг дурдаж, үл мэдэх хэлээр ярих гайхамшигийг оролцуулаад Пэнтээхөст баярын өдөр юу болсныг тайлбарлажээ. Сонирхолтой нь Пэтр Иоелийн үгийг яг нэг бүрчлэн иш татаагүй байна. Септуагинт буюу Грекээр хэлээр бичсэн Еврей Библид Иоелийн үг, “*тэгээд дараа нь Бурхан хэлэхдээ, 'Би бүх хүн дээр Сүнсээ цутгах болно'* гэж хэлсэн билээ” гэж эхэлдэг. Харин Пэтр Иоел номын 2-р бүлгийн 28-ийн эхлэлийг “*Эцсийн өдрүүдэд*” гэж өөрчилж найруулсан байдаг. Пэтр Иоелийн үгийг ингэж өөрчилсөнөөрөө Пэнтээхөст баярын өдөр болсон бүхэн сүүлчийн өдрүүд буюу энэ эрийн үеийн төгсгөлийн нэг хэсэг гэдэгт итгэдгээ харуулсан байна. Харин энэ эрин үе төгсөхөөс өмнө Ертөнцийн Эзэн Сүнсээ цутган буулгана гэсэн Пэтрийн найдварыг Иоел номын бусад хэсэг дэмждэг. Пэтр Иоел номын 2-р бүлгээс иш татаж байгаа нь Ертөнцийн Эзэний Сүнс бууж ирэх явдал нь тэр үед буюу Мөнхийн Эзэний аугаа бөгөөд яруу алдарт өдрийн өмнө болох ажээ.

Хуучин Гэрээний турш энэ Мөнхийн Эзэний өдөр гэдэг нь Ертөнцийн Эзэний шийтгэл болон ивээлийн өдөр болж гардаг. Хуучин Гэрээний нэлээд хэдэн хэсэгт “эцсийн эцэст Ертөнцийн Эзэн дайснуудаа бүрмөсөн ялж, Өөрт нь итгэж найдаж байсан хүмүүсийг ивээх” тухай дурьдсан байдаг. Тийм учраас Пэтр Ариун Сүнс цутган буусан явдлыг Мөнхийн Эзэний аугаа бөгөөд яруу алдарт өдөр ирсний илрэл гэж тайлбарлаж байна. Мөн тэрбээр Пэнтээхөст баярын өдөр болсон бүхэн хүн төрөлхтний түүхийн нэгэн аугаа агшин байсан юм гэж хэлж байна. Пэнтээхөст баярын өдөр Ариун Сүнс ирсэн нь энэ эрин үеийн төгсгөлийн гайхалтай үйл явдал бөгөөд Ертөнцийн Эзэний хаант улсын сүүлчийн үеийг бий болгохын тулд Түүний Өөрийнх нь яруу алдарт оролцоо байсан юм.

Харамсалтай нь өнөө үед Христэд итгэгч маш олон хүн Ариун Сүнс цутган

буусан энэ явдлын аугаа утга учрыг төдийлөн сайн ойлгохгүй байна. Харин үүний оронд Үйл явдал номын 2-р бүлэгт гарсан бүхэн Христэд итгэгч хүн бүрийн ариун болох үйл явцын загвар гэж үзэх нь ихэд түгээмэл болжээ. Бид жинхэнэ сүнслэг итгэгчид нь Пэнтээхөст баярын үеэр, мөн Үйл явдал номын бусад хэсэгт өгүүлсэн Ариун Сүнсний сэтгэл хөдлөм илчлэлт шиг зүйлийг хувьчлан мэдрэх ёстой гэсэн хоосон горьдлогыг бий болгожээ.

Харин үүний оронд ингэж бодох хэрэгтэй. Ертөнцийн Эзэн ер бусын хаант улсаа байгуулж эхлэхийн тулд хэд хэдэн агуу бөгөөд гайхалтай үйлсийг хийсэн талаар Шинэ Гэрээ бидэнд заадаг юм. Христ бидний гэмээс болж нас барж, үхлээд дахин амилаад Ертөнцийн Эзэн Эцгийнхээ баруун гар талд заларч байна. Тухайн хүн итгэлээрээ Христэд хандах бүр эдгээр үйл явдлын ашиг тус нь тухай хүний амьдралд хэрэгжиж байдаг юм. Харин хэн нэгэн хүнийг Өөрт нь итгэж шинэ амьдралтай болох бүр Христ нас бараад, дахин амилаад, тэнгэрт одоод байдаггүй.

Яг үүнтэй адил Пэнтээхөст баярын өдөр Ариун Сүнс ирсэн нь энэ эрин үе төгсөхөөс өмнө Ертөнцийн Эзэний хийсэн дахин давтагдахгүй цорын ганц үйл явдал байсан гэж Шинэ Гэрээ заадаг. Бид удахгүй энэ хичээлээр Үйл явдал номын хэд хэдэн хэсэгт Ариун Сүнс онцгой байдлаар бууж ирсэн явдлууд ч гэсэн дээрхтэй адил цорын ганц үйл явдал болох тухай үзнэ. Христийн сүм дөнгөж бий болж байсан тэр эрт үед итгэгчдэд эрх мэдэл өгөхийн тулд Ариун Сүнс ажиллаж байлаа. Ариун Сүнс итгэгчдийн амьдралд үргэлж нөлөөлж байдаг гэж бид үзэх ёстой нь үнэн. Гэхдээ бид үүнийг яг Пэнтээхөст баярын өдөр ирсэнтэй адил илрэн харагдах ёстой гэж үзэх ёсгүй. Үнэнийг хэлэхэд, Үйл явдал номонд өгүүлсэн Ариун Сүнс хэрхэн ирж байгааг дурдсан бусад тохиолдлууд ч гэсэн хоорондоо яг адилхан байдаггүй. Пэнтээхөст баярын өдөр Ариун Сүнс ирэхдээ ширүүн салхины чимээ сонсогдож, хүн бүрт галын дөл мэт юм хүрч, тэд үл мэдэх хэлээр ярьж ирээдүйг зөгнөн хэлж байсантай адил явдал итгэгч хүн бүрт тохиолддог энгийн нэг хэрэг бишээ. Тэр бүхэн бол Ертөнцийн Эзэн хаант улсаа байгуулж эхэлж байгаагаа илэрхийлсэн Түүний Өөрийнх нь хөндлөнгийн оролцоо байсан юм.

Ийнхүү бид Пэнтээхөст баярын утга учрыг харж, Ариун Сүнс ирэх үед итгэгчид үл мэдэх хэлээр ярьсан гайхамшигийг судаллаа. Одоо бүгдээрээ тэр өдөр болсон үйл явдлын үр дүнгийн талаар үзэцгээе.

Үр дүн

Бид энэ хичээлийн эхэнд Ариун Сүнс Өөрийнх нь төлөөлөгчдөд Ертөнцийн Эзэнийг гэрчлэх эрх мэдэл өгөх тухай Есүс хэлж байсныг та нар санаж байгаа байх. Тийм учраас бид Пэнтээхөст баярын өдөр болсон үйл явдлын үр дүнгийн талаар ярихдаа Ариун Сүнс Есүсийн төлөөлөгчдөд хүч чадлыг хэрхэн өгсөн, улмаар үүнийг хаант улс байгуулах сайн мэдээг түгээхэд хэрхэн ашиглаж байгаад гол анхаарлаа хандуулна. Үүнийг эхэлж үзэхийн өмнө Ариун Сүнс Төлөөлөгч Пэтрт хэрхэн эрх мэдэл олгож байгааг авч үзье.

Бид Луухын сайн мэдээг судалж байхдаа Ариун Сүнс ирэхээс өмнө Пэтр тийм ч ухаалаг шийдвэр гаргаад байдаг хүн байгаагүй гэдгийг мэднэ. Нэгэн удаа Есүс уулан дээр дүр төрхөө хувиргах үед тэрбээр Мөшэх, Элигаах нарт майхан

сүм барихыг хүсээд зэмлүүлдэг. Мөн тэрбээр Их Эзэн Есүсийг баригддаг шөнө түүнээс гурван удаа урвасан билээ. Түүгээр барахгүй Луух Үйл явдал номонд Пэтрийг сайн боловсрол эзэмшээгүй, мөн олныг сэтгэлийг татаж чадахаар үг хэлэх хүн биш гэдэг баримтанд нэлээд анхаарал хандуулсан байдаг. Энэ тухай бичсэн Луухын үгийг Үйл явдал номын 4-р бүлгийн 13-т:

Тэд Пэтр, Иоган хоёрын аймшиггүй зоригтой ярихыг сонсож, ямар ч боловсролгүй жирийн хүмүүс болохыг нь мэдээд гайхавч үнэхээр Есүстэй хамт байсныг нь ойлгов (Үйл явдал 4:13).

Пэтрийн тухай ингэж бичсэнээрээ Ариун Сүнсний хүч чадал түүнийг өөрчилж Пэнтээхөст баярын өдөр Есүсийн тухай сайн мэдээг маш эрч хүчтэй үр дүнтэй заалгаж чадсан гэдэгт огтхон ч эргэлзэх шаардлаггүй болгож байна. Пэтр Пэнтээхөст баярын өдөр тунхагласан сургаалдаа Христэд итгэгчдийг согтуу байна хэмээн буруутгаж байсан хүмүүсийг няцаадаг. Тэрбээр Хуучин Гэрээнээс олон түмэнд итгүүлж чадахаар иш татаж, тайлбарлаж, зөгнөж байсан Аврагч бол Есүс мөн гэдгийг дүрслэн үзүүлдэг. Ариун Сүнс бас Пэтр болон бусад төлөөлөгчдийн тунхаглаж байгаа бүхэн үнэн гэдгийг гэрчлэхийн тулд ер бусын гайхамшигийг үйлдэх хүч чадал өгдөг. Бид энэ тухай Үйл явдал номын 2-34-аас уншдаг. Тэнд:

Ертөнцийн Эзэн төлөөлөгчдөөр олон гайхамгийг бүтээлгэхэд хүмүүс айн бахаддаг байв (Үйл явдал 2:43).

Энэ сайн мэдээг тунхаглахын тулд Пэтр болон бусад төлөөлөгчдөд Ариун Сүнсний өгсөн асар их хүч чадалтай холбож бодсон цагт Ертөнцийн Эзэн тэдний гэрчлэлийг маш их ивээж байсанд гайхах явдалгүй байх аа. Тэдний гэрчлэлийн талаар Луух Үйл явдал номын 2-р бүлгийн 41, 47-д хэрхэн бичсэнийг сонсоцгооё. Тэнд:

Олон хүн түүний үгийг дагаж, усан баталгаа хийлгэхээр болжээ. Тэр өдөр гурван мянга орчин хүн Есүст итгэгч болов. . . . Өдөр бүр Ертөнцийн Эзэн өөр хүмүүсийг Есүст итгүүлж аварсаар байлаа (Үйл явдал 2:41, 47).

Тэгэхлээр Пэнтээхөст баярын өдөр гурван мянган хүн Есүст итгэжээ! Ариун Сүнс эрх мэдэл өгсөн учраас л ингэж гадна талдаа тоо хэмжээний өсөлт гарсан байна. Гэхдээ Христэд итгэгчдийн өсөлт нь зөвхөн гадна талын өсөлт байгаагүй. Үүний үр дүнд итгэгчдийн дотор талд бас өсөлт гарсан байдаг. Энэ тухай өгүүлсэн Луухын үгийг Үйл явдал номын 2-р бүлгийн 42-оос 47 хүртэлх хэсгээс уншицгаая:

Тэд төлөөлөгчдөөр сургаал заалган, нэгдэн нөхөрлөж, Есүс Христийн нас барсныг хамтран тэмдэглэж, талх хувааж идэн, Ертөнцийн Эзэнтэй тогтмол ярьдаг болжээ. . . . Есүст итгэгчид бүх юмаа хувааж эдлэн, зарим нь эд юмаар дутагдахад бусад нь хөрөнгөө худалдаж, гачигдаж дутагдсан нэгэндээ мөнгө өгч тусалдаг байжээ. Өдөр бүр тэд Иерусалим хотын сүмийн хашаанд цугларч, Ертөнцийн Эзэнийг

хүндэтгэн, Есүс Христийн нас барсныг тэмдэглэхээр нэгнийдээ цугларч талх хуваан идэж, хамт хооллодог байв (Үйл явдал 2:42-47).

Анхны итгэгчид Есүсийн төлөөлөгчдийн заасан сургаалын дагуу амьдарч, Ертөнцийн Эзэнд болон нөхдөдөө үйлчилж байсан учраас сүм дотроо ч бас өсөж байлаа. Ийнхүү Пэнтээхөст баярын өдөр Ариун Сүнс ирсэн явдал нь эхэн үеийн Христийн сүмд гайхалтай үр дүнтэй байсан юм.

Пэнтээхөст баярын өмнө болон уг баярын өдөр Ариун Сүнс ямар үүрэг гүйцэтгэсэн талаар Луух хэрхэн бичсэнийг бид үзлээ. Одоо бүгдээрээ Ариун Сүнс Пэнтээхөст баярын дараа ч гэсэн Сайн мэдээ тараах ажилд эрх мэдэл, хүч чадал өгсөөр байсан талаар үзнэ.

ПЭНТЭЭХӨСТ БАЯРЫН ДАРАА

Луух Үйл явдал номонд Пэнтээхөст баярын дараа Ариун Сүнсний хийсний ажлын талаар олон удаа дурдсан байдаг. Бид үүнийг хүмүүст дүрслэн харуулахын тулд зөвхөн гурван хэсэгт л анхаарах болно. Эхлээд бид Шомрон аймгийн нэр нь үл мэдэгдэх нэгэн хотод болсон явдлын тухай үзнэ. Хоёрдугаарт нь Цезаре хотод болсон нэгэн тохиолдолд анхаарлаа хандуулна. Харин гуравдугаарт, бид Эфэс хотод болсон Ариун Сүнсний илчлэлтийг авч үзнэ. За эхлээд Иерусалим хотын хойхон талд буй Шомрон аймагт хийсэн Ариун Сүнсний үйлчлэлийн талаар үзэцгээе.

Шомрон аймаг

Үйл явдал номын 8-р бүлгийн 14-өөс 17-д Ариун Сүнс Есүст итгэгчдэд өөр нэг онцгой аргаар ирж байгаа тухай мэдээлжээ. Тэнд Луух ингэж бичжээ:

Шомрон аймгийнхан Ертөнцийн Эзэний тухай гайхамшигт үнэнд итгэснийг Иерусалим хотын төлөөлөгчид мэдээд Пэтр Иоган хоёрыг тийш явууллаа. Есүст итгэж Филипээр усан баталгаа хийлгэсэн хүмүүст Ариун Сүнс хараахан ирээгүй байсан учраас Пэтр, Иоган хоёр тэдэнтэй уулзаж, 'Ертөнцийн Эзэн минь ээ! Та энэ хүмүүст Ариун Сүнсээ өгнө үү?' гэж гуйгаад гараа хүргэхэд тэд Ариун Сүнсэй боллоо (Үйл явдал 8:14-17).

Ерөнхийдөө Үйл явдал номонд (одоо ч гэсэн) хүмүүсийг Есүст анх итгэсэн мөчид л Ариун Сүнс тэдэнд ирж байсан болохоос хожим хойно нь ирж байгаагүй. Үүнийг харгалзан үзвэл, энд болсон бүхэн Пэнтээхөст баярын өдөр болсон явдалтай төстэй байна. Тэд Есүст итгэснийхээ дараа Ариун Сүнс хүлээн авдаг. Энэ бол Ариун Сүнс цугтан буусан сэтгэл хөдлөм, онцгой мөч байлаа. За тэгвэл яагаад Ариун Сүнс Шомрон аймгийнханд ийм байдлаар ирсэн юм бэ?

Ариун Сүнс ингэж жирийн бус байдлаар ирсэн явдлын хамгийн сайн

тайлбар бол Шомрон аймгийн итгэгчид маш олноороо Христэд итгэсэн явдлыг л онцлон тэмдэглэх зорилготой байсан болов уу. Есүс төлөөлөгчдөдөө Ертөнцийн Эзэний ер бусын хаант улсыг Иерусалимаас Иудей, Шомрон аймаг болон энэ дэлхийн өнцөг булан бүрт хүргэж өргөжүүлэх даалгавар өгснийг та нар санаж байгаа байх. Иудей аймгийн Иерусалим хот нь Пэнтээхөст баярын үеэр үүний эхлэх цэг болсон. Харин Шомрон аймгийнхан бол Иудей болон Иудей бус хүмүүсээс бүрдэх бөгөөд соёл уламжлал нь холилдсон байлаа. Тэд Ертөнцийн Эзэнийг Хуучин Гэрээнд тушаасны дагуу хүндэлдэггүй байв. Тэгэхлээр Сайн мэдээ Шомрон аймагт хүрсэн нь дагалдагчиддаа өгсөн Есүсийн тушаалын биелэлтэнд томоохон ахиц гарч, шинэ шатанд хүрснийг харуулж байгаа юм. Энэ бол өөр үндэстний дунд Сайн мэдээний анхны томоохон тэлэлт байлаа. Шомрон аймгийн итгэгчид Христийн сүмтэй бүрэн нэгдмэл болсныг Есүсийн төлөөлөгчид болон бусад итгэгчдэд нотлон харуулахын тулд Ариун Сүнс тэдэнд үл мэдэх хэлээр ярих эрх мэдэл өгчээ.

Ийнхүү бид Шомрон аймагт хийсэн Ариун Сүнсний ажлыг ойлгосон учраас Пэнтээхөст баярын өдөр болсон бүхнийг сануулах нэгэн тохиолдолдлыг дахин үзэцгээе. Энэ бол Цезаре хотын итгэгчдэд Ариун Сүнс ирсэн явдал юм.

Цезаре хот

Шомрон аймгийн нэр нь үл мэдэгдэх нэгэн хотод болсонтой төстэй үйл явдал Цезар хотод болж байгаа нь Сайн мэдээ анх удаа огт өөр үндэстэний хил хязгаарыг даван орж байгааг тэмдэглэн харуулж байна. Энэ удаа нэлээд хэдэн Иудей бус хүн, бүр тодруулбал Ромын зуун цэргийн дарга Хорнел болон түүний гэр бүл төрөл садан гээд олон хүн Есүст итгэсэн байна.

Үйл явдал номын 10-р бүлгийн 44-өөс 47-д Пэтр Хорнелийн гэр орныхонд Сайн мэдээ ярих үед юу болсон талаар ингэж бичжээ:

Пэтрийг үг хэлэхэд Ариун Сүнс тэнд буй бүх хүнд гэнэт ирж, бүгд янз бүрийн үл мэдэх хэлээр Ертөнцийн Эзэнийг хүндэлж эхлэв. Пэтрийн хамт . . . ирсэн Иудейчууд үүнийг хараад Ертөнцийн Эзэн Иудей бус хүмүүст Ариун Сүнсээ өгснийг мэдээд ихэд гайхжээ. Пэтр тэдэнд хандан, “Төлөөлөгч бидний адил энэ хүмүүс Ариун Сүнстэй боллоо” . . . гэв (Үйл явдал 10:44-47).

Дахиад л Пэнтээхөст баярын өдөр болсон үйл явдалтай гайхмаар төстэй байгаа нь илт байна. Сайн мэдээнд итгэсэн хүмүүс үл мэдэх хэлээр ярьж эхлэв. Пэтр хүртэл Цезаре хотын итгэгчдийг “бидний адил Ариун Сүнстэй боллоо” гэсэн нь Пэнтээхөст баярын өдөр ирсэн Ариун Сүнсийг бас дурдсан болов уу.

Хуучин Гэрээний үед Иудей бус хүмүүс нь Израйльчуудтай байгуулсан Ертөнцийн Эзэний тусгай гэрээнээс ангид байв. Бат итгэлэй Иудейчууд өөрсдийгөө үл итгэгч Иудей бус хүмүүсээс цаг үргэлж тусгаарладаг байлаа. Тэгэхлээр Иудей бус харь хүмүүс эхлээд Иудейн шашинд бүрэн дагаж орохгүйээр Христэд итгэсэн нь анхны итгэгчдийн гайхлыг төрүүлсэн байна.

Ийнхүү Ариун Сүнс ийм гайхалтай арга замаар Хорнел болон түүний гэр

бүлд ирсэн нь эцсийн эцэст Иудей бус хүмүүс аврагдах хаалга нээгдсэнийг харуулж байгаа хэрэг юм. Иудей бус хүмүүс Есүст итгэсэн явдалд итгэгчид хэрхэн хандсаныг Луух Үйл явдал номын 11-р бүлгийн 4, 15, 18-р ингэж бичжээ:

Пэтр “Ертөнцийн Эзэнтэй ярихад минь гэнэт үзэгдэл үзэгдсэн. . . Намайг үг хэлэхэд гэнэт Ертөнцийн Эзэний Ариун Сүнс бидэнд шингэсний адил тэдэнд шингэсэн”. . . гэж бүгдийг тодорхой тайлбарлажээ. Пэтрийн үгийг хүмүүс сонсоод үл эсэргүүцэж, “Ертөнцийн Эзэн Иудей бус хүмүүсийг хүртэл хайрлаж, гэмт амьдралаас нь салгаж, мөнхийн амьдралд орууллаа” хэмээн Ертөнцийн Эзэнийг бахдан хүндлэв (Үйл явдал 11:4, 15, 18).

Ариун Сүнс Иудей бус хүмүүст Пэнтээхөст баярын үеийнхтэй төстэй байдлаар ирсэн нь Есүст итгэсэн тэдний итгэл жинхэнэ бөгөөд Иудей бус хүмүүсээр дамжуулан хаант улсаа байгуулах гэсэн Түүний төлөвлөгөө эхэлснийг батлан харууллаа.

Ийнхүү бид Шомрон аймаг, Цезаре хотод хийсэн Ариун Сүнсний ажлыг үзсэн тул одоо Эфэс хотод болсон явдлын талаар үзэхэд бэлэн боллоо.

Эфэс хот

Энэ явдлыг Үйл явдал номын 19-р бүлгийн 1-ээс 6-д ингэж бичсэн байна:

Пууль . . . Эфэст очиж, Есүс Христэд итгэдэг арваад хүнтэй уулзав. “Та нар Есүс Христэд итгэхдээ Ертөнцийн Эзэний Ариун Сүнснийг хүлээн авсан уу?” гэж тэднээс асуужээ. “Үгүй. Бид тэр Сүнсний тухай огт сонсоогүй” гэж тэд хариулав. “Тэгвэл та нар юуны тулд усаар угаалгасан гэж бодов?” хэмээн Пууль асуухад, “Бид Жоганбаптисын хэлсний дагуу угаал үйлдсэн” гэж хариуллаа. Гэмт амьдралаа орхихыг хүссэн хүмүүсийг Жоган усаар угаан өгч, “Та нар миний дараа ирэх хүнд л итгэх хэрэгтэй” гэж Израйльчуудад хэлдэг байсан. Тэр хүн бол Есүс байлаа гэж Пууль хэлсэнд тэд Их Эзэн Есүст итгэснээ батлан Пуулиар угаалгажээ. Пууль хүн бүрт гараа хүргэхэд Ариун Сүнс тэдэнд ирж мэдэх мэдэхгүй янз бүрийн хэлээр Ертөнцийн Эзэний тухай яриулжээ (Үйл явдал 19:1-6).

Бид дахиад л Пэнтээхөст баярын өдөр болсон бүхэнтэй тун төстэй үйл явдлыг харж байна. Тэдэнд Есүсийн нэрээр усан баталгаа хийлгэсний дараа Ариун Сүнс ирж тэд янз бүрийн үл мэдэх хэлээр Ертөнцийн Эзэний тухай зөгнөн ярьжээ.

Луух энэ хэсэгт Иудей болон Шомрон аймгаас хол оршдог Бага Азийн хойгийн томоохон хот болох Эфэст Ариун Сүнс сэтгэл хөдлөм байдлаар ирсэн тухай бичжээ. Ер нь Луух Ариун Сүнсний ажил Иерусалимаас эхлээд Шомрон аймгийг дамжин Иудей бус хүмүүст хэрхэн хүрч өргөжсөнийг аль хэдийн олж тогтоосон билээ. Харин энд Ариун Сүнснийг хүлээн авсан хүмүүс нь Жоганбаптисын дагалдагчид байсан нь жирийн бус хэрэг байлаа. Эд бол

Жоганбаптисын сургаалийг сонсоод гэмт амьдралаа орхисон боловч “Есүс бол Израйльчуудын удаан хүлээсэн Аврагч мөн” гэсэн түүнийг үгийг хараахан сонсоогүй Еврей хүмүүс байсан бололтой.

Энэ нь Үйл явдал номын бүр эхнээс Луухын цохон тэмдэглээд байсан Жоганбаптис Есүс хоёрын хоорондын харилцааны асуудалд цэг тавьсан учраас л Луух үүнийг онцолж бичсэн юм. Үйл явдал номын 1-р бүлгийн 5-д Есүс үйлчлэлээ Жоганбаптисын үйлчлэлтэй сөргүүлэн:

Жоганбаптис гэмт амьдралаа орхих дуртай олон хүнийг усаар угаан баталж өгсөн. Харин Ертөнцийн Эзэн та нарыг өөрийнхөө Ариун Сүнстэй болгон баталж өгнө (Үйл явдал 1:5).

Эфэс хотод Жоганы дагалдагчид Ариун Сүнсийг хүлээн авсан тухай өгүүлсэн энэ түүх нь Ариун Сүнстэй болгох Есүсийн ажил нь цоо шинэ түвшинд гарсныг харуулж байна. Жоганы дагалдагчид хүртэл Христийн Сүнсийг хүлээн авч Түүний дагалдагч боллоо. Христийг бүрэн хүлээн авч Ариун Сүнсний хүч чадлаар амьдрах нь Ертөнцийн Эзэний хүсэлтэй нийцэж байна.

Төлөөлөгчид Христэд итгэгчдэд оноосон үйлчлэлийг урагш ахиулах бүр, ер бусын хаант улсын хил хязгаарыг тэлж буй тэдний ажлыг Ариун Сүнс сэтгэл хөдлөм байдлаар буун ирж баталгаажуулж байна. Ариун Сүнсний хүч чадлаар Сайн мэдээ юунд ч саатахгүйгээр Иерусалим хотоос Иудей, Шомрон аймгийн дамжин энэ дэлхийн өнцөг булан бүрт хүрсэн билээ. Өнөөдөр ч гэсэн Ариун Сүнсний хүч чадал бол Христийн сүмийг өөрчлөх, Сайн мэдээг үр дүнтэй тараах цорын ганц арга зам юм. Бид ч гэсэн Ертөнцийн Эзэнд бат итгэлтэй болж, Сайн мэдээний үгийг бусдад үр дүнтэй гэрчлэхийг хүсэж байгаа бол Ариун Сүнсний хүч чадалд л найдах хэрэгтэй.

ТӨЛӨӨЛӨГЧИД

Ийнхүү бид Ариун Сүнсний гүйцэтгэсэн үүргийн талаар авч үзсэн тулд Есүсийн төлөөлөгчид хэмээх хоёрдахь гол сэдэвтээ орцгооё. Христ тэнгэрт одохынхоо өмнө Сайн мэдээгээр дамжуулан Хаант улсаа Иерусалимаас эхлээд энэ дэлхийн өнцөг булан бүрт хүргэх ажлыг нь үргэлжлүүлэн хийх Төлөөлөгчдийг сонгосон билээ. Бид энэ хичээлийн эхэнд Үйл явдал номын 1-р бүлгийн 8-д анхны итгэгчдэд Ариун Сүнсний гүйцэтгэх чухал үүргийг тодорхойлсон талаар үзсэн. Бүгдээрээ Төлөөлөгчиддөө хандсан хэлсэн Есүсийн үгийг дахин сонсоцгооё:

Харин түүний Ариун Сүнс та нартай нэгдэн асар их хүч чадал өгч Иерусалим хот, Иудей, Шомрон аймаг байтугай энэ дэлхийн өнцөг булан бүрт илгээн, миний тухай яриулах болно (Үйл явдал 1:8).

Бид хичээлийнхээ энэ хэсэгт дээрх ишлэлээс урган гарсан хоёрдахь асуудал болох Есүсийн төлөөлөгчдийн гүйцэтгэх үүрэгт гол анхаарлаа хандуулна.

Яг л энд Есүсийн хэлсэнчлэн, Төлөөлөгчдөд Ариун Сүнс өгснөөр тэд дэлхий даяар Түүний тухай гэрчлэх ярих ажээ.

Эхэн үеийн Христийн сүмийн хувьд хүнд хэцүү тааламжгүй нөхцөлд Сайн мэдээг тунхаглаж буй хүмүүсийг “итгэлийнхээ төлөө зовон тарчлагч” эсвэл “гэрчүүд” гэдэг байв. Заримдаа туйлын хүнд хэцүү нөхцөлд тэд Христийг бусдад тунхагласнаас болж зодуулж тамлуулж, түүгээр ч барахгүй алуулдаг байлаа. Үнэндээ бол, Есүсийн ихэнх төлөөлөгчид иймэрхүү байдлаар нас барсан гэж Христийн сүмийн түүх бидэнд өгүүлдэг. Эсэргүүцэлтэй тулгарч байсан ч Христийг тунхаглаж байсан гэдэг энэ сэдвийг Луух анхны итгэгчдийн тухай бичихдээ үргэлж анхаарч байв. Христийг зоригтой, үр дүнтэй тунхаглаж чадсанаараа Төлөөлөгчдийг давах хүн байдаггүй юм.

Христийг гэрчлэх ажилд Төлөөлөгчдийн гүйцэтгэсэн үүргийн гурван тал дээр бид анхаарлаа хандуулна. Нэгдүгээрт, тэдний гэрчлэл хосгүй байсан талаар үзнэ. Хоёрдугаарт, бид энэ гэрчлэл нь эрх мэдэлтэй байсныг харна. Харин гуравдугаарт, бид тэдний гэрчлэл олон янзын шинж чанартай байсныг, өөрөөр хэлбэл тэд Сайн мэдээг янз бүрийг аргаар танилцуулж байсан талаар судлана. За ингээд бүгдээрээ Төлөөлөгчдийн алба тушаалын хосгүй шинжийн талаар үзэж эхэлье.

Хосгүй

Төлөөлөгчид наад зах нь хоёр зүйлээр хосгүй байлаа. Юуны өмнө тэдний албан тушаалд тавигдах шаардлага нь өөр хэн нэгэн хүнийг Есүсийн төлөөлөгч гэж хэлэгдэх боломжгүй болгосон.

тавигдах шаардлага

Есүсийн анхны арван хоёр төлөөлөгчийн нэг болох Хариот хотын Иудас нь Их Эзэнийг маань цовдолсон хүмүүсийн талд урвасан гэдгийг бид мэднэ. Хожим Иудас амиа хорлосон тул зөвхөн арван нэгэн төлөөлөгч үлдсэн билээ. Есүсийг тэнгэрт одсоны дараа эдгээр арван нэгэн хүний хийх анхны чухал ажлын нэг нь Иудасын оронд нэг хүнийг арван хоёрдахь төлөөлөгч болгон сонгох явдал байлаа.

Үйл явдал номын 1-р бүлгийн 21-ээс 26-д шинээр сонгогдох төлөөлөгчид тавигдах шаардлагыг Пэтр ингэж тодорхойлжээ:

“Тийм учраас Есүс нас барсан боловч Ертөнцийн Эзэн дахин амилуулсан гэдгийг гэрчилж чадах хүн төлөөлөгч болох нь зүйтэй. . . үргэлж бидний хамт байсан тийм нэг хүн хэрэгтэй” гэв. Тэд . . . хоёрын нэрийг дэвшүүлж, “Их Эзэн минь ээ! . . . Та түүний оронд төлөөлөгч болох хүнийг сонгосон. Энэ хоёрын аль нь болохыг бидэнд мэдэгдэнэ үү?” гэж Ертөнцийн Эзэнээс гуйгаад шодоход Матиас болох нь батлагджээ (Үйл явдал 1:21-26).

Эдгээр ишлэл нь Төлөөлөгчийн албан тушаалд тавигдах шаардлагыг тогтоосон байна. Энэ бүхэн Библид бичигдсэн төлөөлөгчдийн хувьд хосгүй шаардлага байсан юм. Нэгдүгээр, тэд Есүсээр шууд сургаал заалгасан хүмүүс байв. Хоёрдугаарт, тэд Есүсийг дахин амилсаных нь дараа харсан хүмүүс байлаа. Гуравдугаарт, тэднийг энэ албан тушаалд Ертөнцийн Эзэн Өөрөө томилсон билээ. Арван нэгэн төлөөлөгч нь бүгд газар дэлхий дээр Есүсийн хийсэн үйлчлэлийн үеэр Түүгээр сургаал заалгаж, Түүнийг дахин амилсаны дараа харсан бөгөөд тэднийг Есүс Өөрөө сонгож энэ албанд нь томилсон юм.

Матиас энэ бүх шаардлагыг биелүүлэв. Учир нь тэр бас Есүсийг энэ дэлхийд байхад нь сургаал заалгаж, дахин амилахад нь нүдээрээ харж, шодуулж байхдаа Ертөнцийн Эзэнээр шууд сонгогдсон юм.

Библид бичсэнээр бол Матиасын дараа зөвхөн ганц л хүн Есүсийн төлөөлөгчөөр томилогдсон нь Пууль байлаа. Пууль Есүсийг тэнгэрт одсоны дараа Түүний төлөөлөгч болж сонгогдсон учраас Христэд итгэгчид эхэндээ түүний энэ томилгоонд итгэлгүй ханддаг байв. Харин Бичээс бидэнд, үнэндээ бол Пууль Есүсийг нас барсаны дараа харж, сургаал заалгаж, түүгээр ч барах Есүс өөрөө түүнийг томилсон гэж заадаг билээ.

Жишээлбэл, Үйл явдал номын 9-р бүлгийн 3-аас 6-д Луухын бичсэнчлэн, Пууль Дамаск хотод очих замдаа дахин амилсан Их Эзэнийг харсан байна. Мөн түүнийг энэ албан тушаалд Ертөнцийн Эзэн томилсоныг бид Үйл явдал номын 9-р бүлгийн 15, 22-р бүлгийн 12-аас 16-р ишлэлүүдээс уншдаг.

Түүгээр ч барахгүй Пууль Есүсийг тэнгэрт одсоны дараа Түүнд итгэсэн болохоор Төлөөлөгч болгохоор өөрт нь тавигдсан шалгуур зарим талаараа жирийн бус байсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Пууль өөрийгөө Есүсийн хосгүй онцгой төлөөлөгч гэдгээ 1 Коринфийн 15-р бүлгийн 8, 9-д:

Тэдний дотроос би отгон хүү мэт болж, хамгийн сүүлд Есүс Христийг үзлээ. Би түүний төлөөлөгчдийн дотроос хамгийн дорд нь гэж өөрийгөө тооцдог (1 Коринф 15:8-9).

суурийг тавих үе

Иймэрхүү хосгүй шалгуурт нийцэхээс гадна Төлөөлөгчид нь Христийн сүмийн амьдралд бүхний суурийг тавих үед ажиллаж байснаараа онцгой байсан. Энэ онцгой цаг үед тэд Есүс Христийн сүмийг үндэслэн байгуулах үүрэг хүлээсэн юм. Тэгэхлээр тэд ажлаа хийсэн учраас, тэдний байгуулсан суурин дээр Христийн сүм баттай байгуулагдсан учраас, дахиж ийм онцгой ажлыг хийх шаардлага хэзээ ч гарахгүй.

Есүсийн төлөөлөгчид нь Түүний сүмийн үндсийг тавих үүрэг гүйцэтгэсэн гэдгийг Луух олон арга замаар өгүүлдэг. Төлөөлөгчид бол Сайн мэдээг Иерусалим хотоос эхлээд Иудей Шомрон аймгийг дамжин энэ дэлхийн өнцөг булан бүрт хүргэсэн хамгийн гол гэрч нар байсан гэдгийг бид өмнөх хичээлээр үзсэн. Тэд авралын зар тараасан учраас л Иудейн шашинаас, Шомрон аймгийнханы завхарсан шүтлэгээс, Иудей бус хүмүүсийн мухар сүсэг дундаас Христэд итгэгч хүмүүс гарч

ирсэн билээ. Тэдний удирдлагаар хүн төрөлхтний түүхэнд анхны Христийн сүм бий болсон бөгөөд улмаар энэ бүхэн дараа дараагийн сүмийн загвар болсон юм. Энэ бүхнээс эргээд харахад Есүсийн төлөөлөгчид нь цаг хугацааны онцгой үед хосгүй ажлыг хийсэн байдаг. Энэ үе нь дахиж хэзээ ч ирэхгүй бөгөөд энэ ажлыг дахиад хийж дуусгах ямар ч шаардлага байхгүй.

Пууль Эфэс номын 2-р бүлгийн 19, 20-д Төлөөлөгчдийн гүйцэтгэсэн бүхнийг үндэслэн байгуулах үүргийг нь ингэж хураангуйлан дүгнэжээ:

Та бүхэн . . . түүний . . . гэр бүлд багтсан юм. Энэ нь хамтарч барьсан нэгэн их барилга мэт. Барилгын суурь нь Есүсийн төлөөлөгчид ба зөнчид гэвэл та нар тэр суурь дээр босгосон хана билээ (Эфэс 2:19-20).

Тэгэхлээр дахиж хэзээ ч өөр үндэс, өөр Есүс гарч ирэхгүй. Яг үүнтэй адил, дахиж хэзээ ч Христийн сүмийн өөр үндэс суурь байгуулагдахгүй. Сүмийн үндэс болж үйлчлэх өөр төлөөлөгч, өөр зөнч гэж гарч ирэхгүй.

Харамсалтай нь, өнөө үед ч гэсэн өөрсдийнхөө дунд ийм эрх мэдэлтэй төлөөлөгч үйлчилж байна гэж тунхагласан сүмүүд байсаар л байна. Харин анхны төлөөлөгчид нь өөрсдийн албан тушаалд тавигдах шаардлагад хосгүй нийцэж, дахиж хэзээ ч давтагдахгүй суурийг тавих онцгой цаг үед үйлчилж байсан гэдгийг Луух тодорхой харуулсан байдаг. Бидэнд Шинэ Гэрээний номнуудад буй Есүсийн төлөөлөгчдийн үйл хэргийн гэрчлэл байсаар байна. Харин бид өнөөгийн сүм цуглаан дотор иймэрхүү төлөөлөгчид дахин гарч ирнэ гэж үзэж огт болохгүй.

Эрх мэдэлтэй

Ийнхүү Төлөөлөгчид нь Христийг бусдад хосгүй арга замаар тунхаглан таниулж байсныг үзсэн тул одоо тэдний тунхаглалын эрх мэдэлтэй шинж чанарыг нь судалцгаая. Төлөөлөгчдийн эрх мэдэл Үйл явдал номын турш олон янзын арга замаар харагддаг. Харин бид үүнийг амар хялбар таниулах үүднээс эдгээрээс дөрөв дээр нь анхаарлаа хандуулна. Нэгдүгээрт, Төлөөлөгчдийн эрх мэдэл нь тэдний эрхлэх албан тушаалын үйл ажиллагаанаас харагддаг. Хоёрдугаарт, энэ нь тэдний үйлчлэлд буй Ертөнцийн Эзэний ивээлээс харагддаг. Гуравдугаарт, энэ нь гайхамшигт үйлс бүтээж буй тэдний хүч чадлаас тод харагддаг. Харин дөрөвдүгээрт, энэ бүхэн тэдний хүлээн авсаар байгаа илчлэлтээс илэрхий байдаг. За эхлээд бүгдээрээ Төлөөлөгчдийн албан тушаалын үйл ажиллагаа нь тэдний эрх мэдлийг харуулж байгааг үзэцгээе.

Үйл ажиллагаа

“Төлөөлөгч” гэдэг нь илгээгдсэн хүн гэсэн утгатай Грек хэлний “апостолос” гэсэн үг юм. Энэ нь ихэвчлэн аливаа үүрэг даалгаврыг гүйцэтгэхээр илгээсэн элч, бие төлөөлөгч эсвэл илгээсэн хүнийхээ төлөөлж үг хэлэх эрх мэдэлтэй элчин

сайдыг хэлдэг байжээ. Жишээлбэл, Луух номын 10-р бүлэгт Есүс Ертөнцийн Эзэний хаант улсын тухай тунхаглуулахаар далан хоёр хүнийг сонгосон тухай өгүүлдэг. Тэд бол тодорхой хугацаанд Христийн эрх мэдэлтэй болсон Түүний түр зуурын элчин сайд нар байсан. Луух номын 10-р бүлгийн 16-д Есүс тэр элч нартаа:

Та нарын үгийг дагасан хүн намайг дагаж байгаа хэрэг. Та нарыг басамжилсан хүн намайг бас басамжилж байна. Ертөнцийн Эзэн намайг илгээсэн учраас намайг бассан хүн түүнийг бас басамжилж байна (Луух 10:16).

Эндээс бид илгээсэн далан хоёр дагалдагч нь Христийн орлогч нар шиг ажиллаж байгааг харлаа. Эдгээр элчийн үгийг дагасан хүмүүс Христийг хүлээж авсантай адил байна. Тэд Христийг хүлээн авсан учраас Түүнийг илгээсэн Ертөнцийн Эзэн-Эцгийг хүлээж авсантай адил байна.

Дээрх элч нар буцаж ирээд юу гэж ярьсаныг Луух номын 10-р бүлгийн 17-аас 19-д ингэж бичжээ:

“Таны нэрийг хэлэнгүүт л муу ёрын сүнс хүнээс зайлж байсан” гэж тэд Есүст хэлэхэд, “Адгийн муу ёрын сүнс тэнгэрээс цахилгаан мэт харван доош буухыг би үзсэн. Түүний үргэлжийн эрх дархтай байдал ийнхүү алга болов. Би та нарт ер бусын эрх чадал өгсөн учраас аюулт хүчтэн, ямар ч муу ёрын сүнсийг та нар хорт могой, олгой хорхойг бяц гишгих мэт дийлж чадна. Та нарыг харин ямар ч хүч дийлэхгүй” . . гэж тэр ярилаа (Луух 10:17-19).

Есүс энэ далан хоёр хүнийг өөрийн элч болгохдоо тэдэнд эрх мэдлийнхээ зарим хэсгийг өгсөн байна. Тиймээс Есүсийг төлөөлж буй тэдний төлөөлөл нь зөвхөн бэлэг тэмдэг төдий байгаагүй юм. Тэд бол эрх мэдэлтэй төлөөлөгч нар байсан юм. Тэд ямар ч алдаа гаргадаггүй багш нар байгаагүй ч, адгийн муу ёрын сүнсийг зайлуулж, ер бусын хаант улс байгуулагдаж байгааг тунхаглах эрх мэдэлтэй байсан.

Яг үүнтэй адил Төлөөлөгчид нь эрх мэдэлтэй элчин сайд нар байсан юм. Гэхдээ Үйл явдал номонд бичсэнээр бол Христийг төлөөлж буй тэдний төлөөлөл нь бусад дагалдагчдаас хоёр чухал зүйлээр ялгаатай байлаа. Нэгдүгээрт, Төлөөлөгчид нь зөвхөн Сайн мэдээг тараах үүрэг хүлээсэн бус, Христийн сүмийн албанд байнга ажиллахаар томилогдсон болохыг Луухын бичсэн энэ түүх тодорхой харуулдаг. Үйл явдал номонд Төлөөлөгчид нь хэн нэгэн хүний байрыг эсвэл албан тушаалыг эзлэх талаар огт бичээгүй. Тэд Христийн олгосон эрх мэдлийг түр зуур бус, цаг үргэлж эдэлж байлаа. Хоёрдугаарт, Төлөөлөгчид нь Христийн сүмийг байгуулах болон удирдах бүх л асуудлаар үг хэлэх эрх мэдэлтэй байв. Үйл явдал номын 15-р бүлэгт өгүүлсэн Иерусалим дахь Ахлагч нарын зөвлөлтэй холбоотой хэсгээс харвал Төлөөлөгчдийн үгийг сүм тэр чигээрээ хүлээн авдаг байжээ. Тэдний гаргасан ямар ч шийдвэрийг Ертөнцийн Эзэний хүсэл хэмээн хүлээн авдаг байв. Төлөөлөгчдийн эрх мэдлийг Пэтр хэрхэн дүрсэлснийг 2-р Пэтр 3-р бүлгийн 2-оос сонсоцгооё. Тэнд:

Би та бүхнийг . . . төлөөлөгчдөөр дамжуулан өгсөн бидний Аврагч болон Их Эзэний маань тушаалыг эргэн санахыг хүсэж байна (2 Пэтр 3:2).

Пэтр энд Төлөөлөгчид Есүсийн хүслийг биелүүлж, сургаалыг нь заах ажилд найдвартай үйлчилж байсан учраас тэдний үгийг хүлээн авах хэрэгтэй гэдгийг харуулсан байна.

Нэгэнт бид Төлөөлөгчдийн үйл ажиллагааг тодорхойлсон тул Сайн мэдээ тараах ажлаар дамжуулан тэдний онцгой хосгүй үйлчлэлийг Ертөнцийн Эзэн хэрхэн ивээсэн талаар үзэцгээе.

Ивээл

Ер нь Төлөөлөгчдийг Сайн мэдээг тунхаглах бүр Ертөнцийн Эзэн маш олон хүнийг Есүст итгүүлж тэднийг ивээдэг байсан талаар Үйл явдал номонд өгүүлдэг. Пэнтээхөст баярын өдөр заасан Пэтрийн номлолоос болж 120 хүнтэй байсан Христийн сүм 3000 хүнээр нэмэгдэж байгааг бид үзсэн. Иймэрхүү ивээл Үйл явдал номын турш гардаг.

Уг номын зохиогчийн хувьд Луух Христийн сүм нь гадна байдлаараа тооны хувьд ингэж өсөж байгаа нь Ертөнцийн Эзэн тэднийг хүлээн зөвшөөрч хүч чадал өгсний нотолгоо гэдгийг уншигчиддаа тун няхуур зааж байна. Нотолгоондоо Паараш бүлгийн хүндэт багш Гаамалиелийн үгээс хүртэл иш татаж оруулдаг. Үйл явдал номын 5-р бүлгийн 38, 39-д бичсэнээр бол Иудейчүүдийн ахлагч нарын зөвлөлийн өмнө Гаамалиель Төлөөлөгчдийн тухай ингэж хэлжээ:

Хэрэв энэ хүмүүс дээд тэнгэрээс эрх чадал аваагүй бол өөрсдийн дураар дургиад юу ч болохгүй. Харин Ертөнцийн Эзэн тусалж байгаа бол эднийг хэн ч устгаж чадахгүй. Тэгвэл бид Ертөнцийн Эзэнийг эсэргүүцсэн хэрэг болно. Иймээс тэднийг зөнд нь орхи (Үйл явдал 5:38-39).

Үүнийг анхааран авч үзвэл, Сайн мэдээг тарааж буй Төлөөлөгчдийн үйлчлэлийг Ертөнцийн Эзэн ивээж байсан нь Ариун Сүнс тэдний үйлчлэлийг шалгаж үзээд эрх мэдэл өгсний нотолгоо юм.

Төлөөлөгчдийн үйл ажиллагаанаас харагдах нотолгоо, Сайн мэдээ тараах үйлчлэлийг нь Ертөнцийн Эзэн маш олон удаа ивээж байгаагаас гадна, тэдний эрх мэдэл үйлчлэлтэй нь дагалдаж буй гайхамшигт үйлсээс бас харагддаг.

Гайхамшигт үйлс

Библийн турш гарах гайхамшигт үйлсийн нэг гол үйл ажиллагаа нь Ертөнцийн Эзэний илгээсэн хүмүүс үнэнийг хэлж, Түүний өгсөн эрх мэдэлтэй

байгааг нотлох явдал байлаа. “Египетээс гарсан нь” номонд Мөшэх Египетийн Фараоны өмнө Ертөнцийн жинхэнэ Эзэнийг төлөөлөн ярьж байгаагаа нотлохын тулд олон гайхамшиг үйлдсэн тухай гардаг. “Хаадын дээд” ба “Хаадын дэд” номонд Элийгаах, Элишаа нар Ертөнцийн Эзэнээс ирсэн зөгнөл сургаалаа баталгаажуулахын тулд гайхамшигийг үйлдэж байгаа тухай өгүүлдэг. Сайн мэдээний номнуудад Есүс өөрийгөө хүн төрөлхтөнийг аварч удирдахын тулд Ертөнцийн Эзэний илгээсэн Аврагч, Тос дусаалган томилогдсон зарц, мөн Зөнч гэдгээ нотлохын тулд олон гайхамшиг үйлдсэн тухай гардаг билээ.

Яг үүнтэй адил Үйл явдал номонд өгүүлсэн Төлөөлөгчдийн үйлдсэн гайхамшгууд нь Христийн тухай тэдний ярьж буй гэрчлэл үнэн гэдгийг нотолж байна. Төлөөлөгчид өвчтэй хүн эдгээснийг Үйл явдал 5-р бүлгийн 16-д, Төрөлхийн суумгай хүнийг эрүүл болгосныг 14-ийн 8-д, Нас барсан хүнийг дахин амилуулсаныг 9-ийн 40-д, ёрын муу юм хийдэг хүнийг зовоон тарчлаасан тухай 13-ийн 11-д бичсэн. Мөн тэд шоронгоос зугтааж чадсаныг 12-ийн 10-д, усан онгоцны сүйрлээс амьд гарсныг 27-ийн 44-т, хорт могойд хатгуулсан ч үхэхгүй байгааг 28-ийн 3-т тус тус бичсэн байна. Үнэндээ бол тэд ер бусын маш их хүчтэй байсан. Үйл явдал номын 5-ийн 15-д бичсэнээр бол Пэтрийн сүүдэр туссан хэн ч гэсэн эдгэж байжээ. Түүгээр ч барахгүй Пуулийн хувцасаар муу ёрын сүнснийг зайлуулж, өвчтэй хүнийг эдгээж байсан тухай 19-р бүлгийн 11, 12-д бичсэн байдаг. Ийм хүч чадлаар бүтсэн гайхамшиг зөвхөн Ертөнцийн Эзэнээс л ирэх боломжтой бөгөөд Төлөөлөгчид бол Түүний жинхэнэ эрх мэдэлтэй гэрч нар гэдгийг нотолж байна. Тийм учраас Пууль өөрийн хийж байсан гайхамшигт үйлсийг 2-р Коринфын 12-р бүлгийн 12-т:

Ертөнцийн Эзэн олон хүчтэй гайхамшигтай үйл явдал надаар хийлгэж, Есүсийн жинхэнэ төлөөлөгч болохыг минь ер бусын аргаар олон удаа баталсан (2 Коринф 12:12).

Ариун Сүнсний хүч чадлаар хийгдсэн ер бусын гайхамшигт үйлс нь Есүсийн төлөөлөгч хүний шинж тэмдэг бөгөөд тэрбээр Христ болон түүний ажлыг үнэхээр гэрчилж байгаагийн нотолгоо болсон байна.

Бид Төлөөлөгчдийн үйл ажиллагааг, тэднийг Сайн мэдээ тарааж байх үед Ертөнцийн Эзэн хэрхэн ивээж байгааг, мөн тэд гайхамшигт үйлс бүтээж байгаа талаар үзлээ. Одоо бүгдээрээ тэдний хүлээн авсан илчлэлт эрх мэдлийг нь хэрхэн нотолж байгааг үзэцгээе.

Илчлэлт

Ариун Сүнс Төлөөлөгчдөд удирдамж өгч, Сайн мэдээний үнэнийг хөгжүүлж тэднийг удирдаж, сүмийн бүх гишүүдэд хамаатай шийдвэр гаргаж, сүмийг өсөн төлөвших боломж олгосон бүтцийг бий болгож байсан талаар Луух олон удаа бичсэн байдаг. Жишээ нь, Үйл явдал номын 10-р бүлэгт, Иудей бус хүмүүсийг Христэд итгэгч болгохын тулд тэднээс эхлээд Иудейн шашинд бүрэн орохыг шаардахгүйгээр хүлээн авах тухай заасан Ертөнцийн Эзэний үзэгдлийг Пэтр хардаг. Мөн 16-р бүлэгт Пууль Македони аймагт Сайн мэдээг тунхаглаж

Ертөнцийн Эзэний хаант улсыг асар их өргөжүүлж болох тухай өгүүлсэн үзэгдэл үздэг.

Луухын анхны уншигчид болон эхэн үеийн сүмийн бусад гишүүдийн хувьд Есүсийн төлөөлөгчдийн үйл ажиллагаа, тэднийг үйлчлэлийг Ертөнцийн Эзэн ивээж, тэд гайхамшгийг үнэхээр үйлдэж, илчлэлт хүлээн авсан зэрэг нь тэдний эрх мэдлийн маргашгүй нотолгоо болж байв. Тиймээс Луух Үйл явдал номын турш эхэн үеийн итгэгчид нь Төлөөлөгчдийн заасан бүх сургаалийг хүлээн авч, гаргасан шийдвэр бүрт нь захирагдаж тэдний эрх мэдэлд хариулж байгаа талаар өгүүлсэн байдаг. Яг үүнтэй адил, өнөөгийн Христэд итгэгчид хүртэл Христийн эрх мэдэлтэй элчин сайд болсон энэ хүмүүсийн хэлсэн Үйл явдал номонд буй үгс болон Шинэ Гэрээний бусад хэсэгт буй сургаалд бас захирагдах хэрэгтэй.

Бид Төлөөлөгчдийн гэрчлэл нь хосгүй бөгөөд эрх мэдэлтэй байсан гэдгийг үзсэн. Одоо бүгдээрээ тэд болон тэдний дагалдагчид Христийн тухай сайн мэдээг хүн төрөлхтөнд гэрчлэн таниулахдаа олон янзын арга хэрэглэж байсан талаар үзэцгээе.

Олон янз

Үйл явдал номын турш Төлөөлөгчид болон тэднийг дагаж байсан хүмүүс Христийг бусдад таниулахдаа олон янзын арга хэрэглэж байсан талаар өгүүлэх бидний яриа хоёр хэсгээс бүрдэх болно. Эхлээд бид Христийг гэрчлэн ярьж байхдаа тэдний хэрэглэсэн янз бүрийн стратегийг авч үзнэ. Хоёрдугаарт, бид Христийн тухай ярихдаа тэд янз бүрийн орчинг ашиглаж байсан талаар дурдана. За эхлээд Үйл явдал номонд буй тэдний ашигласан янз бүрийн стратегийн талаар судалцгаая.

Стратеги

Христийг бусдад танилцуулахдаа Төлөөлөгчид болон тэдний дагалдагчдын ашиглаж байсан стратегийг маш олон арга замаар тодорхойлж болох ч, зургаан гол арга замын талаар бодож үзвэл ашиг тустай байх болов уу. Нэгдүгээрт, тэд түүхээс ялангуяа Есүс Христийн амьдрал, үхэл дахин амилалт зэрэг Ромын Эзэнт улс даяар мэдээлэгдсэн үйл явдлыг анхааран үзэхийг уриалж байв. Жишээлбэл, Үйл явдал номын 26-р бүлгийн 26-д Пууль Агрипп хаанд:

Миний ярьсан бүхэн олны нүдэн дээр биелэгдсэн учраас та мэдэхгүй өнгөрөх ёсгүй. Иймээс ч би чөлөөтэй ярьж байна. Ертөнцийн Эзэний эртний зөнчдийн үг биелэх болно гэдэгт та ч бас итгэдгийг би мэднэ (Үйл явдал 26:26).

Энэ хэсэгт, түүний болон Есүст итгэгчдийн тунхаглаж буй гол баримт нь эртний тэр ертөнцөд олны мэдэх үйл явдал байсан гэдгийг л Пууль онцолж хэлжээ. Иймэрхүү түүхэн үйл явдалд анхаарлаа хандуулахыг уриалах нь үл итгэгчдэд

Есүсийн тухай тунхаглахдаа Төлөөлөгчдийн түгээмэл ашиглаж байсан стратеги юм. Хоёрдугаарт, Төлөөлөгчид авралын зар тараах хүчин чармайлтандаа дэмжлэг авахын тулд Бичээсийн үнэнд хандахыг уриалж байлаа. Төлөөлөгчид Еврейчүүдэд Есүсийн тухай таниулахдаа Хуучин Гэрээ рүү байнга ханддаг байв. Жишээ нь, Үйл явдал номын 3-р бүлгийн 22-т Пэтр, Есүс бол Еврейчүүдийн удаан хүлээсэн Аврагч мөн гэдгийг тэдэнд нотлохын тулд Мөшэхийн үгэнд хандсан байдаг. Уг номын 23-р бүлгийн 6-д Пууль Хуучин Гэрээнээс урган гарсан, “Нас барсан хүн дахин амилдаг” гэсэн Иудейчуудийн итгэлийг анхаарч үзэхийг хүссэн байдаг.

Гуравдугаарт, Төлөөлөгчид Иудей бус хүмүүст Есүс Христийн тухай гэрчлэхдээ байгаль дэлхийд харагдаж буй Ертөнцийн Эзэний илчлэлт болон Бүтээгч Эзэнээ мэдэхгүй хүмүүсийн үзэл бодолд буй жинхэнэ итгэлд ханджээ. Жишээлбэл, Пууль Афинчуудад Сайн мэдээг танилцуулахдаа эхлэх цэг болгож Бүтээгч Эзэнээ мэдэхгүй харанхуй хүмүүсийн Ертөнцийн Эзэний тухай үзэл бодол болон хүн төрөлхтөний түүхийг ашиглаж байгааг 17-р бүлгийн 24-ээс 27-д ингэж бичжээ. Тэр юу гэж хэлснийг бүгдээрээ сонсоцгооё:

Хорвоо ертөнц хийгээд түүнд орших бүх юмыг бүтээсэн аугаа их хүчит эзэн бол Ертөнцийн Эзэн юм. Тэр Их Эзэн хорвоогийн бүх хүнд амь нас, аль хэрэгцээтэй бүхнийг өгдөг учир хүн төрөлхтний бүтээсэн ямар ч сүмд орж суухгүй, ямар ч юмыг хэрэглэхгүй. Тэр Их Эзэн өнө эрт нэгэн хүнийг бий болгож, даян дэлхийн бүх үндэстнийг тэр хүнээс эхлэн үүсгэсэн байна. Ертөнцийн Эзэн тэр олон хүнийг хаана, хэзээ бий болгохоо өнө эртнээс шийдсэн байжээ. Үүнийг хийхдээ хүмүүс өөрийг нь хүсэмжлэн хайж олоод ойр дотно болохыг Ертөнцийн Эзэн хүсжээ. Басхүү Ертөнцийн тэр Эзэн маань хорвоогийн хүмүүс биднээс холгүй оршдог ажээ (Үйл явдал 17:24-27).

Энд Пуулийн танилцуулсан үзэл бол Христэд итгэгчид болон Иудейчуудаас гадна Бүтээгч Эзэнээ мэдэхгүй олон хүнд бас хамаатай юм. Үнэнийг хэлэхэд Пууль Афин хотын Арейпагт дээрх үгийг хэлж байхдаа тэдний утга зохиолоос иш татдаг билээ. Энэ тухай 17-р бүлгийн 28-д:

“Биднийг Ертөнцийн Эзэн бүтээж, амь нас өгч алтан дэлхийд алхуулдаг” гэж танай нэг хүн хэлжээ. “Бид бүгд Ертөнцийн Эзэний бүтээсэн хүүхдүүд билээ” гэж бас нэг яруу найрагч чинь бичсэн байна (Үйл явдал 17:28).

Пууль Афин хотод Христийн тухай гэрчилж байхдаа Христэд итгэх итгэлийн танилцуулга болгож Грекийн яруу найраг руу ханджээ.

Дөрөвдүгээрт, Төлөөлөгчид бусдад Христийн тухай танилцуулж байхдаа хувь хүний туршлагад олон удаа хандаж байв. Пууль энэ аргыг олон удаа хэрэглэсэн талаар Луух Үйл явдал номонд бичжээ. Жишээлбэл, Дамаск хот орох замд өөрт нь тохиолдсон сэтгэл хөдлөм явдлыг Пууль дурдаж байгааг уг номын 9-р бүлэгт Луух бичсэн байна. Пууль энэ явдлаа Иерусалим хотод Иудей олон түмний

өмнө ярьсаныг 22-р бүлэгт, Агрип хааны өмнө хэрхэн дүрсэлж өгүүлснийг 26-р бүлэгт тэрбээр дахин бичсэн байдаг.

Тавдугаарт, Төлөөлөгчид нь өөрсдийн тунхаглаж буй Сайн мэдээг үнэн гэдгийг нотлохын тулд маш олон шинж тэмдэг үзүүлж, гайхамшигийг үйлдэж байв. Энэ хичээлийн эхэнд үзсэнчлэн, Үйл явдал ном нь Төлөөлөгчдийн хийсэн гайхамшигт үйлсээр дүүрэн байгааг бид харсан. Ариун Сүнс Төлөөлөгчдөд гайхамшигийг үйлдэх эрх мэдлийг өгч байхдаа Есүс Христийн тухай тэдний гэрчлэлд тусалж байсан юм.

Зургаадугаарт, Төлөөлөгчид нь Христэд тууштай үнэнч зангаараа Сайн мэдээг гэрчилж байв. Тэд хүмүүсийг Христ рүү чиглүүлж байхдаа бусдын анхаарлыг их татдаг байсан бөгөөд үүнийгээ ч байнга ашигладаг байв. Тэд хавчигдаж, аюул заналхийлэлд өртөж байхдаа ч гэсэн Христийг бусдад таниулах дуудлагаасаа огт татгалзаж байсангүй. Жишээ нь, Үйл явдал номын 14-р бүлэгт Луустар хотын хүмүүс Пууль Барнаб хоёрыг бурхан болгож шүтэх гэхэд Пууль өөрийгөө энгийн нэгэн хүн гэдгийг учирлаж хэлээд цугласан олныг Ертөнцийн Эзэн руу хандуулдаг. 4-р бүлэгт Иудейчуудын ахлагч нарын зөвлөл Төлөөлөгчдийг заналхийлж, Христийн тухай ярихаа зогсоохийг тушаахад тэд Түүний талаар ярихгүй чимээгүй байхаас татгалздаг. Бид энэ тухай 5-р бүлгийн 28, 29-д:

Сүмийн тэргүүн төлөөлөгчдийг харж, “Есүсийн тухай хэнд ч ярьж болохгүй” гэж бид тушаасан . . . гэж хэллээ. Пэтр бусад төлөөлөгчдийн хамт зөвлөлийн гишүүдэд хандан, “Ертөнцийн Эзэний үг хэний ч үгтэй зүйрлэшгүй хүчтэй. Тийм учраас бидэнд та нарын үгийг дагах хэрэг байхгүй . . .” гэлээ (Үйл явдал 5:28-29).

Ийнхүү Төлөөлөгчид Сайн мэдээг гэрчлэн ярьж байхдаа олон янзын стратеги хэрэглэсэн байна. Тэд өөрсдийн үлгэр жишээ болон сургаал номлолоороо дамжуулан анхны итгэгчдэд дээрх олон янзын стратегийг хэрхэн хэрэглэхийг бас заасан юм. Үйл явдал номонд буй Луухын тэмдэглэлийн энэ онцлог шинж нь Сайн мэдээг гэрчлэн ярихдаа биднийг ашиглаасай гэж Ертөнцийн Эзэний хүссэн стратегиудийг хайж буй үе үеийн Христэд итгэгчдийг урамшуулан зоригжуулах ёстой юм.

Бид Христийг бусдад танилцуулахын тулд Төлөөлөгчдийн ашиглаж байсан олон янзын стратегиас гадна Христийг гэрчлэхийн төлөө тэдний ашиглаж байсан өөр өөр орчинг бас авч үзэх хэрэгтэй.

Орчин

Бид Үйл явдал номонд Төлөөлөгчдийн Сайн мэдээг гэрчлэн таниулж байсан янз бүрийн орчинг олон янзаар хураангуйлан бичиж болох байх. Гэхдээ амар хялбар байх үүднээс эдгээр орчинг үндсэн дөрвөн ангилалд орууллаа. Нэгдүгээрх нь, олон түмний өмнө үг хэлсэн тухай юм. Бид энд Төлөөлөгчид олон нийт цуглардаг газар хүмүүст сургаал заах, итгэлээ хамгаалж маргалдах зэрэг янз бүрийн хэлбэрээр үг хэлж байсан үйл явдлуудыг сэтгэлдээ тунгаах болно.

Төлөөлөгчид иймэрхүү маягийн танилцуулга хийхдээ өөрсдийнх нь үгийг

сонсож буй хүмүүст хэлэх үгээ тун нямбай сонгодог байв. Тэд Иудейчуудад нэг янзаар, Иудей бус хүмүүст өөр янзаар Христийг танилцуулдаг байсныг бид аль хэдийн энэ хичээлийн явцад үзсэн билээ.

Хоёрдугаарт, Төлөөлөгчид харилцан яриа буюу маргааны явцад Христийг танилцуулдаг байв. Энэ орчинд Төлөөлөгчид эхлээд хүмүүсийн дунд эсрэг тэсрэг үзэл бодлыг бий болгочихоод дараа нь Сайн мэдээг хамгаалдаг байлаа. Жишээлбэл, 19-р бүлэгт Пууль Туран гэдэг хүний танхимд мэтгэлцээн өрнүүлдэг. Эфэст байсан энэ газарт хүмүүс олны өмнө уран илтгэх чадвараа үзүүлж, аливаа шинэ санаагаа шалгуулан мэтгэлцдэг байжээ.

Гуравдугаарт, Үйл явдал номонд Төлөөлөгчид болон тэднийг дагаж байсан хүмүүс айлын гэр оронд очиж Христийн тухай ярьдаг байв. Эртний дэлхий дахинд тухайн айлын гэр оронд зөвхөн эцэг эх нь хүүхдүүдтэйгээ амьдардаг байгаагүй. Төрөл садан, найз нөхөд, гэрийн зарц нар гээд олуулаа амьдардаг байв. Тийм учраас бид Үйл явдал номноос ямар нэг айлын тухай олж уншвал тэнд гэрийн эздээс гадна үр хүүхдүүд, өвөө эмээ нар мөн нагац, авга гээд хамаатнууд, бас хөлсний ажилчид, зарц нар, тэгээд заримдаа бүр боолчуудыг хамтад нь төсөөлөн бодох хэрэгтэй. Гэр оронд дунджаар 15-аас 20 хүн хамт амьдардаг байсан бололтой. Бид Үйл явдал номноос Төлөөлөгчид айлын гэр оронд очиж Христийн тухай гэрчлэн ярьж байгаа олон жишээг харсан. Жишээлбэл, 10-р бүлэгт Пётр Хорнелийн гэр бүлийнхэнд Христийн тухай ярьдаг бол 16-р бүлэгт Пууль Лүүд гэгч эмэгтэй болон Филипой хотын шоронгийн харгалзагчийн гэрт очиж Христийг гэрчилсэн байдаг.

Дөрөвдүгээрт, хувьчлан авралын зар тараахыг бусдад Христийг гэрчлэн ярих нэг хэлбэр болгож Үйл явдал номонд оруулсан байна. Жишээлбэл, 25-р бүлэгт Пууль Агрип хаантай хувьчлан уулзахдаа түүний мэдлэг, амьдралын туршлагатай нийцүүлж Сайн мэдээг ярьдаг билээ.

Товчхон хэлэхэд, Төлөөлөгчид бусдад Христийн тухай ярихдаа тодорхой хэдэн орчинд, яг таг хэдэн арга барилд өөрсдийгөө хязгаарлаагүй аж. Бид Үйл явдал номыг судалж байхдаа, тэд Сайн мэдээг танилцуулахдаа боломж бүрийг ашиглаж, өөрсдийнх нь үгийг сонсож байгаа хүмүүст тохирох арга хэрэглэж байсан юм байна гэдгийг олж мэддэг. Төлөөлөгчид үүгээрээ бидний үгийг сонсож буй хүмүүст хамгийн сайн тохирох Сайн мэдээний хэсгийг онцолж, Сайн мэдээг итгэгч бүрийн амьдралтай холбох тусгай арга замыг олох жишээг бидэнд хэлж өгч, зааж байна.

СҮМ

Ийнхүү бид Ариун Сүнс, Төлөөлөгчид гэсэн хоёр гол сэдвийг үзлээ. Одоо бүгдээрээ Үйл явдал номынхоо гуравдахь гол сэдэв болох Төлөөлөгчдийн байгуулсан сүмийн тухай үзэцгээе.

Бид Сүм гэсэн сэдвийг хоёр замаар судлана. Нэгдүгээрт нь, Сүм зайлшгүй шаардлагатай болох талаар үзнэ. Харин хоёрдугаарт, Төлөөлөгчид ажлаа үргэлжлүүлэхийн тулд Сүм байгуулахаар хэрхэн бэлтгэж байсныг үзнэ. За одоо

бүгдээрээ Сүм зайлшгүй шаардлагатай болох талаар үзэцгээе.

ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ БАЙДАЛ

Христ Өөрт нь итгэдэг хүмүүсийн сүм байгуулах үүргийг Төлөөлөгчдөд өгсөн билээ. Яагаад ийм үүрэг өгсөн юм бол? Цөөхөн хэдэн хүн өөрсдөө Христийн тухай үгийг бүх дэлхийд хүргэж чадахгүй гэдгийг Төлөөлөгчид мэдэж байсан. Тиймээс тэдэнд Ер бусын хаант улсын тухай өгүүлэх Сайн мэдээг улс орон бүрт тунхаглаж чадах үй олон гэрч хэрэгтэй байжээ.

Төлөөлөгчдөд оноосон даалгаврыг биелүүлэхийн тулд Сүм зайлшгүй шаардлагатай болсон хоёр хүчин зүйлийг бид үзнэ. Эхлээд бид Төлөөлөгчид бие махбодын хувьд хязгаарлагдмал байсан буюу тэд өөрсдөд нь оноосон үүргийг өөрсдийн биеэр бүрэн гүйцэтгэж чадахгүй гэдэг баримтыг үзнэ. Хоёрдугаарт, тэд цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байсан тухай буюу хүмүүний амьдралын энгийн үргэлжлэх хугацааны турш л амьдарч байсан болохоор ирээдүй үеийнхэнд Христийг гэрчлэх боломжгүй гэдэг баримтыг үзнэ. За ингээд Төлөөлөгчид бие махбодын хувьд хязгаарлагдмал байсан талаар үзэцгээе.

Бие махбодын хязгаарлагдмал байдал

Сайн мэдээг тунхаглаж Христийг бусдад гэрчлэх нь Төлөөлөгчдийн ажил байсан гэдгийг бид аль хэдийн үзсэн. Гэхдээ тэд өөрсдөө дэлхийд бүхэлд нь хүрч чадах “амьд үгс” байж чадахгүй билээ. Энэ асуудлыг шийдэхийн өмнө тэд Христийн жинхэнэ гэрч байх үүрэг хариуцлагынхаа нэлээд хэсгийг Сүмд хариуцуулан өгчээ. Төлөөлөгчдийн тараасан авралын зарын үр дүнд олон хүн Христийн сүмд нэмэгдэж ирсэн бөгөөд тэд өөрсдийн эрхийн хүрээнд “амьд үгс” болсон юм. Тэд Сайн мэдээгээр амьдарч байсан тул гэр орныхондоо, хөршүүддээ Есүсийн тухай гэрчлэн ярьж байлаа. Тэдний зарим нь бүр миссионер, Сайн мэдээ тараагчид болсон байдаг. Ийм арга замаар шинэ үе бүрт Сүм ихэнх ажлыг хийж жинхэнэ авралын зарыг тараагаад байж чадах өөрөө өөрсдийгөө хуулсан загварыг Төлөөлөгчид бий болгожээ. Мэдээж хэрэг Сүм нь Төлөөлөгчдийн номлолын үеэр харагддаг эрх мэдэл, гайхамшигт нотолгоог үзүүлж байгаад авралын зар тарааж чадахгүй л дээ. Гэсэн хэдий ч үг хэлээрээ ч, бодит амьдрал дээр ч харуулсан Сүмийн жинхэнэ гэрчлэлийг Ариун Сүнс таашаасан хэвээр байсан бөгөөд ийм арга замаар маш олон шинэ хүн Христэд итгэдэг байна.

Жишээлбэл, 11-р бүлгийн 19-ээс 21-д хавчлагаас бол тарж зугтсан итгэгчдийн тухай юу гэж хэлснийг сонсоцгооё. Энд:

. . . Есүс Христэд итгэгчид ихэд хавчигдах болж, газар сайгүй зугтан, Сири улсын Фойних аймаг, Кипр арал, Антиох хотод . . . очиж Иудейчуудад Есүсийн тухай гайхамшигт үнэнийг зарлав . . . зарим хүн Сири улсын Антиох хотод ирж, Иудей бус хүмүүст Есүс Их Эзэний тухай ярилаа. Их Эзэн тэдэнд тусалж, маш олон хүнийг

өөртөө итгүүлжээ (Үйл явдал 11:19-21).

Төлөөлөгчид бие махбодын хувьд хязгаарлагдмал байсан гэдгийг нэгэнт ойлгосон болохоор тэдний нас баралттай холбогдож буй болсон цаг хугацааны хязгаарлагдмал байдлын тухай үзье.

Цаг хугацааны хязгаарлагдмал байдал

Есүс эргэж ирнэ гэдэгт Төлөөлөгчид итгэж байсан боловч хэзээ гэдгийг нь мэдэхгүй байлаа. Үйл явдал номын 12-р бүлэгт Хэрэд хаань Яхобыг сэлэмдүүлж алуулсан тухай өгүүлдэг. Ингээд Есүсийг эргэж ирэхээс өмнө Төлөөлөгчдийн зарим нь амьд байхгүй гэдэг нь тодорхой болов. Тийм учраас Төлөөлөгчид Есүст итгэгчдийг шууд удирдан Сайн мэдээ заахаас гадна өөрсдийг нь нас барсаны дараа Сүм байгуулах ажлыг үргэлжлүүлэн хийхэд сургаж байлаа. Жишээлбэл, Эфэсийн сүмийн ахлагч нарт хандан Пуулийн хэлсэн үгийг 20-р бүлгийн 25-аас 28-д:

Би та нарын дунд сууж, Ертөнцийн Эзэний ер бусын улсын тухай тунхаглаж байсан. Үүнээс хойш бид дахин уулзалдахгүйг би ойлгов . . . Тэр хүмүүсийг харж хамгаалахыг Ертөнцийн Эзэний Ариун Сүнс та нарт даалган ахлагчаар томилжээ. Тийм учраас төлөв даруу байж, хүлээсэн үүргээ биелүүлэхтүн (Үйл явдал 20:25-28).

Сүм нь Сайн мэдээг тууштай тарааж итгэгчдийг бүрэн төлөвшилд хүргэхийн тулд Христээс хамааралтай байгаасай гэж Пууль хүссэн. Тийм учраас тэрбээр өөрийг нь нас барсаны дараа энэ сүмийн удирдагчид үйлчлэлээ үргэлжлүүлэхэд бэлтгэгдсэн эсэхийг нягтлан асууж байна. Нэгэнт л Төлөөлөгчид бие махбодын ч, цаг хугацааны ч хувьд хязгаарлагдмал байсан тул Ертөнцийн Эзэний хаант улсыг урагшлуулах гэсэн тэдний урт болон богино хугацааны стратегид сүм гол үүрэг гүйцэтгэх болсон байна.

Жинхэнэ гэрчлэл хийхэд Сүм зайлшгүй шаардлагатай гэдгийг бид үзлээ. Одоо Сүмийг Төлөөлөгчид хэрхэн бэлтгэсэн талаар үзэцгээе.

БЭЛТГЭЛ

Төлөөлөгчид Ертөнцийн Эзэний ер бусын хаант улсыг өргөжүүлэх ажлыг үргэлжлүүлэхийн тулд Сүмийг олон аргаар бэлтгэсэн байдаг. Харин цаг хугацааны боломж бидэнд гурван зүйлийг л авч үзэхэд хүргэж байна. Нэгдүгээрт, Төлөөлөгчид Христийг найдвартай тунхагласан өөрсдийн найдвартай гэрчлэлээ багтаасан сургаалд нь үнэнч хэвээр байхыг Сүмд зааварчилсан баримтыг бид судлана. Хоёрдугаарт, хүнийг ахлагч, туслагч гэх мэт сүмийн албан тушаалд томилохын тулд Төлөөлөгчид ямар заавар өгч байсан талаар судлана. Гуравдугаарт, Төлөөлөгчид зайлшгүй тулгарах бэрхшээл саадыг тэсвэрлэн давахад Сүмийг хэрхэн бэлтгэж байгааг бид харна. За ингээд бүгдээрээ Сүмд дамжуулан

өгсөн Төлөөлөгчдийн сургаалийн талаар үзэцгээе.

Сургаал

Эфэсийн 2-р бүлэгт Сүмийг барилга гээд, уг барилгын тулгын чулууг Христ, харин үүний суурийг Төлөөлөгчид ба Зөнчид гэж дүрсэлсэн байдаг. Эфэсийн 2-р бүлгийн 19, 20-д буй Пуулийн үгийг сонсоцгооё:

Та бүхэн . . . түүний бусад хүмүүсийн хамт ер бусын улсад нь орж, гэр бүлд нь багтсан юм. Энэ нь хамтарч барьсан нэгэн их барилга мэт. Барилгын суурь нь Есүсийн төлөөлөгчид ба зөнчид гэвэл . . . Есүс Христ бол тэр барилгын тулгын чулуу мөн (Эфэс 2:19-20).

Төлөөлөгчид зөвхөн Сүмийн анхны удирдагчид байгаад зогсохгүй, тэдний сургаал нь Христэд итгэгчдийн итгэл үнэмшлийнх нь үндэс суурь гэдгийг Пууль бас энд хэлж байгааг бодолцож үзэх нь чухал болов уу. Эфэсийн 3-р бүлгийн 4-ээс 6-д Пууль зааж байсан сургаалийнхаа гол үүргийг:

Есүс Христ далдын ямар зорилгоо надад илэрхийлснийг одоо та нар уншаад ойлгох болно. Урьд өмнө Ертөнцийн Эзэн энэ зорилгоо хүмүүст тодорхой мэдэгдээгүй байна. Харин одоо өөрийн сонгож авсан төлөөлөгчид болон зөнчдөд Ариун Сүнсээрээ дамжуулан үүнийгээ илэрхийлжээ (Эфэс 3:4-6).

Тийм учраас л Үйл явдал номонд Сүм Төлөөлөгчдийн сургаалд өөрсдийгөө бүрэн зориулсан гэдэг баримтыг Луух тун няхуур онцолсон байдаг юм. Тэрбээр үүнийг 2-р бүлгийг 42-д:

Тэр бүлгийнхэн төлөөлөгчдөөр сургаал заалган . . . (Үйл явдал 2:42).

Христэд үнэнч байхын тулд, Түүний ер бусын улсыг өргөжүүлэх бидний оролдлогыг Ертөнцийн Эзэн ивээхийн тулд Сүм нь Христийг тулгын чулуугаа болгохоос гадна эхэн үеийн сүмийн гишүүд болох Төлөөлөгчид болон зөнчдийг сууриа болгох хэрэгтэй гэдгийг Луух уншигчиддаа мэдүүлэхийг хүссэн юм. Төлөөлөгчид нь Христийн сургаал, ажил үйлсийг нь бусдад эрх мэдэлтэйгээр, зохих ёс журмын дагуу шилжүүлсэн билээ. Тийм учраас Л шинэ үе бүрийн итгэгчид Төлөөлөгчдийн заасан сургаалийг тунхаглаж, хэвээр нь хадгалж, мөн уг сургаалийн дагуу амьдрах хэрэгтэй.

Энэ нь өнөөгийн Христийн сүмд ч гэсэн үнэн хэвээрээ л байна. Шинэ Гэрээний ихэнх хэсгийг Төлөөлөгчид бичсэн явдал нь энэ бүхэн өнөө үед ч үнэн байх хамгийн тодорхой шинж тэмдэг юм. Харин Үйл явдал мэтийн Төлөөлөгчдийн бичээгүй номууд нь тэдний зөвшөөрлийг авсан байдаг. Өнөөгийн Христийн сүм болсон бид амьдралаа Есүсийн төлөөлөгчдийн заасан сургаалийн жинхэнэ эмхэтгэл болсон Шинэ Гэрээний номын дагуу барьж байгуулдаг билээ.

Ийнхүү Есүсийн төлөөлөгчид өөрсдийн заасан сургаалд үнэнч байхыг Сүмд

зааж тэднийг бэлтгэж байсан талаар үзлээ. Тиймээс Сүм шинэ газар нутагт өргөжин тэлж, шинэ үе гарч ирэх бүрт тэднийг удирдах албан тушаалтануудыг Төлөөлөгчид хэрхэн бэлтгэсэн талаар үзэхэд бэлэн боллоо.

Албан тушаалтан

Төлөөлөгчид өөрсдөө Ертөнцийн Эзэний өгсөн даалгаврыг биелүүлж дуусгахад нь саад болсон бие махбодын болон цаг хугацааны хязгаарлалттай тулгарсан гэдгийг бид үзсэн. Энэ төвөгтэй асуудлыг шийдэх нэг гарц нь Сүмд нэмэлт албан тушаалтануудыг бий болгох явдал байв.

Бүгдээрээ энд түр азнаж байгаад, Христийн уламжлалт янз бүрийн сүм цуглаан эхэн үеийн сүмийн удирдлага болон албан тушаалыг олон янзаар ойлгодог байсан гэдгийг хэлэх хэрэгтэй байх. Христийн сүмийн зарим салбар пастор, ахлагч, туслагч гэсэн гурван албан тушаалыг хүлээн зөвшөөрдөг байна. Бусад нь ахлагч, туслагч гэсэн хоёрхон албан тушаалыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Мөн зарим нь дээрх албан тушаалуудаас гадна төлөөлөгч, миссионер, авралын зар тараагч гэх мэт өөр олон албан тушаалыг хүлээн зөвшөөрсөн байдаг.

Сүмийн зөв удирдлагын талаар үзэх нь энэ хичээлийн хамрах хүрээнээс ахадсан асуудал боловч, Сүм Ертөнцийн Эзэний өгсөн даалгаврыг биелүүлэхийн тулд л Төлөөлөгчид иймэрхүү нэмэлт албан тушаалыг бий болгосон юм шүү гэдгийг бид онцлон хэлэхийг хүсэж байна.

Үнэнийг хэлэхэд, Төлөөлөгчид сүмийн нэмэлт албан тушаал бий болгохоо тун хурдан ойлгосон байдаг. Учир нь тэд өөрсдөө Иерусалим хотын нутгийн сүмтэй холбоотой үйлчлэлийг ч гэсэн хийж барахгүй юм байна гэдгээ бараг тэр даруй ухаарсан байна. Сүмийн гишүүдийн хэрэгцээг хангахын тулд Төлөөлөгчид туслагч нарын албан тушаалыг бий болгож байгааг бид Үйл явдал номын 6-р бүлгээс тодорхой хардаг. Энэ тохиолдолд бол өдөр бүр хүнс тараах үүрэг хүлээсэн хүмүүсийг сонгох зааврыг Төлөөлөгчид сүмд өгдөг билээ. Энэ асуудлыг Төлөөлөгчид хэрхэн шийдэж байгааг 6-р бүлгийн 3-аас 6-д:

[Төлөөлөгчид хамтран хуралдаж], “Нөхөд өө! . . . та нарын дундаас нэр хүндтэй, Ариун Сүнсний хүч бүхий эрдэм чадалтай долоон эрийг сонгон авч ажиллуулбал бид гайхамшигт үнэнийг газар сайгүй тунхаглаж, Ертөнцийн Эзэнтэй ярьж чадна” гэхэд хүн бүр талархан дэмжиж . . . долоон хүнийг сонгож, төлөөлөгчдийн өмнө суулгав. Төлөөлөгчид Ертөнцийн Эзэнтэй ярьж, тэр долоод гар хүргэн баталжээ (Үйл явдал 6:3-6).

Төлөөлөгчид нь Христийн гол сүмд харьяалагдах янз бүрийн жижиг бүлгүүдийг удирдаж халамжилж байх пастор буюу ахлагч нарыг бас томилсон байна. Жишээ нь, Пууль авралын зарын аялалынхаа үеэр шинэ итгэгчдийг гол төлөв сүмд цуглуулаад өөрийг нь явсаны дараа тэднийг удирдах ахлагч нарыг томилдог байв. Үүнтэй холбоотой нэг жишээг Луух 14-р бүлгийн 23-д:

Пууль, Барнаб хоёр . . . тэр гурван хотод Их Эзэнд итгэдэг хүмүүсийн

бүх бүлгийн ахлагч нарыг томилон мацаг барьж, “Энэ хүмүүс бүгд танд итгэж байна. Та тэднийг хайр хамгаалалдаа авна уу?” хэмээн Их Эзэнээс гуйв (Үйл явдал 14:23).

Үнэнийг хэлэхэд Төлөөлөгчид Сүмийн ахлагч нарыг бэлтгэхэд ихэд анхаарч хамт дагуулж явж, түүгээр ч барахгүй өөрсдөө амьд байхдаа тэднийг сүм цуглаан удирдахыг дэмждэг байлаа. Үүнтэй холбоотой Үйл явдал номын хамгийн алдартай жишээ бол Иудей бус хүмүүсийг Сүмийн бүрэлдэхүүнд хэрхэн нэгтгэх асуудлаар Иерусалимын итгэгчдийн ахлагч нарын зөвлөл хуралдсан хэсэг билээ. Энэ зөвлөлийг төлөөлөгчид, ахлагч нар хамтран удирдаж байлаа. Энэ хурлын тухай өгүүлсэн 15-р бүлэгт төлөөлөгч, ахлагч нарыг хамтад нь наад зах нь таван удаа Сүмийн удирдагч мэтээр дурдсан байдаг. Бүгдээрээ одоо энэ хурал хэрхэн эхэлж байгааг 15-р бүлгийн 1, 2-р ишлэлээс үзэцгээе. Тэнд:

Гэтэл хэдэн хүн Иудей аймгаас Сирийн Антиох хотод ирж, “Хэрэв та нар Мөшэхийн бичсэн сургаалын дагуу хөвч хөндүүлээгүй бол Ертөнцийн Эзэн мөнхийн зовлонгоос хэзээ ч аврахгүй” гэж Есүст итгэгчдэд сургадаг болов. Пууль, Барнаб хоёрыг тэдэнтэй ихэд маргалдсаны дараа хэдэн нөхдийн хамт Иерусалим хотод очиж, Есүсийн төлөөлөгчид болон бүлгийн ахлагч нартай энэ асуудлыг хэлэлцсүгэй хэмээн зарим нь зөвлөөд үдэн гаргаж өгчээ (Үйл явдал 15:1-2).

Пуулийг хэдэн хүний хамт төлөөлөгчид болон ахлагч нараас зөвлөгөө авахуулахаар явуулж байна. Бид төлөөлөгчид болон ахлагч нар гэсэн энэ холбоо үгийг яг энэ бүлгийн 4, 6, 22, 23-р ишлэлээс бас олж хардаг.

Төлөөлөгчдийг Үйл явдал номын турш Ертөнцийн Эзэний илгээсэн аврагчийн хаант улсыг байгуулах сүмийн албан тушаалтан шиг нэрлэсэн байдаг. Бид үүнийг 20-р бүлэгт Эфэсийн сүмийн ахлагч нарыг Пууль удирдаж байсан жишээнээс хардаг. Мөн үүнийг 15, 21-р бүлэгт Иерусалим хотын сүмийг удирдаж байсан Яахообын бусдыг удирдах гайхалтай үүргээс бас олж хардаг билээ. Пууль Сүмийн албан тушаалтныг томилох талаар Титийн 1-р бүлгийн 5-д ингэж бичжээ:

Би Крит арлаас явахдаа чамд олон үүрэг өгч үлдээсэн. Үүний дотроос хамгийн чухал нь чи миний хэлсэн дагуу Критийн бүх хотод Есүст итгэгчдийн бүлгийн ахлагч нарыг томилох ёстой (Тит 1:5).

Энд Пууль өөрийн дуусгаагүй ажлаа гүйцээлгэхээр залуу пастор Титэд заавар өгч байна. Өөрөөр хэбэл Төлөөлөгч Пуулийн эхэлсэн ажлыг Ахлагч Тит дуусгаж байна. Харин Пууль Ертөнцийн Эзэнийн ер бусын хаант улсыг тэлэх сайн мэдээ тараах Төлөөлөгч хүнийхээ ажлыг цааш үргэлжлүүлжээ.

Пууль болон бусад төлөөлөгчид хийж байсан үйлчлэлээ шилжүүлэн өгөхийн тулд эдгээр албан тушаалтныг сонгон томилсон байна. Ертөнцийн Эзэн Төлөөлөгчдийг бүгдийг өөрсдөө хийгээсэй гэж хүсээгүй. Тэрбээр Төлөөлөгчдөөр зөвхөн Өөрийнхөө сүмийг байгуулахыг л хүссэн юм. Мөн Өөрийн байгуулсан сүмийн удирдлагыг хүлээн авах хүмүүсийг тэд нараар сургахыг хүссэн. Харин

тэдгээр албан тушаалтан нь Төлөөлөгчдийн байгуулсан үндэс суурийг үргэлжлүүлж, тэдний хэзээ ч хүрэхгүй газар нутагт, хэзээ ч очиж чадахгүй ирээдүйд Ертөнцийн Эзэнийн хаант улсыг өргөжүүлэн тэлж чадна.

Ийнхүү Төлөөлөгчид Сүмд Есүсийн сургаал болон үйлсийн талаар зааж, Түүний ажлыг гүйцээхийн тулд сүмийн албан тушаалуудыг бий болгосон тухай үзлээ. Одоо харин Төлөөлөгчид цааш урагшлах тусам сүмд зайлшгүй тулгарах саад бэрхшээлд Есүст итгэгчдийг хэрхэн бэлтгэж байсан талаар үзэхэд бэлэн боллоо.

Бэрхшээл саад

Луух Төлөөлөгчдийн ажлыг аюултай, хэцүү, хавчлага зовлонгоор дүүрэн гэж дүрсэлсэн байдаг. Тэд цаг үргэлж баривчлагдаж, зодуулж байлаа. Түүгээр ч барахгүй Хэрэд хаан төлөөлөгч Яхобыг цаазлав. Өөрсдөд нь тохиолдож байгаа энэ бүх явдал Христэд итгэгч бусад хүнд бас тохиолдоно гэдгийг Төлөөлөгчид мэдэж байв.

Пуультай холбоотой нэг онцгой хэсэг байдаг. Түүнийг Луустар хотод уурлаж хилэгнэсэн үл итгэгчид чулуугаар шидэж үхтэл нь зоддог. Маргааш нь Пууль Дирбэ хот руу зугтаадаг. Харин дараа нь тэрбээр Луустар болон бусад хотод дахиж очоод Есүст итгэгчдэд урам зориг өгдөг. Пуулийн амьдралын яг энэ үеийг 14-р бүлгийн 21, 22-г:

[Пууль, Барнаб хоёр] Дирбэ хотод гайхамшигт үнэнийг тунхаглаж, олон хүнийг Есүс Христэд итгүүлээд, Луустар, Ихонион, Писид аймгийн Антойч хотоор дахин явахдаа хүмүүсийн итгэлийг батжуулж, “Та нар Их Эзэнд ямагт итгэгчтүн! Хожим бид Ертөнцийн Эзэний ер бусын мөнхийн улсад орохоосоо өмнө янз бүрийн зовлон туулах болно” хэмээн сургажээ (Үйл явдал 14:21-22).

Христэд итгэгчид бэрхшээл саад, хавчлага зовлонтой тулгарна гэдгийг ойлгоосой гэж Төлөөлөгчид хүссэн. Зарим нь итгэлээсээ болж алуулах болно. Гэхдээ ер бусын хаант улсыг байгуулах зорилго нь бүхнээс үнэ цэнэтэй юм. Тийм учраас Сүм Христэд тууштай үнэнч байх шаардлагатай байлаа.

Төлөөлөгчид Христэд итгэгчдийг бэрхшээл саадад бэлтгэж байсаныг Эфэсийн сүмийн ахлагч нарт хэлсэн Пуулийн алдарт үгнээс бас харж болно. Үйл явдал номын 20-р бүлэгт Пууль тэд нартай дахиж бараг уулзахгүй байх гэж хэлдэг. Тэрбээр Иерусалим хотод очоод баривчлагдаж, улмаар алуулах байх гэдгээ ч бас тэдэнд хэлдэг. Ийнхүү Пууль өөрийн амьдралын бараан дүр зургийг өгүүлэхдээ, Эфэсийн сүмийнхэнд тулгарах бэрхшээл саадад бэлтгэх сануулга сэрэмжлүүлгийг өгч байна. Эфэсийн ахлагч нарт түүний хэлсэн үгийг 20-р бүлгийн 28-аас 31-д ингэж бичжээ:

Тэр хүмүүсийг харж хамгаалахыг Ертөнцийн Эзэний Ариун Сүнс та нарт даалган ахлагчаар томилжээ. Тийм учраас төлөв даруу байж,

хүлээсэн үүргээ биелүүлэгтүн. Намайг эзгүйд араатан мэт хүмүүс та нарын дунд ирж Есүс Христэд итгэдэг, номхон хот мэт хүмүүсийг бусниулна. Тэд та нарын дунд орж, итгэл олж авахын тулд худал хэлнэ. . . буруу замд хальтран орохоос болгоомжлогтун (Үйл явдал 20:28-31).

Нэлээд хэдэн төлөөлөгч үүнтэй төстэй зүйлийг Есүст итгэгчдэд бичсэн байдаг. Пэтр, Иоган, Пууль нар бүгд л Сүмийг Христэд үнэнч байж, Библи болон тэдний сургаалыг түшиж, итгэлийн дайснуудаас нь сэрэмжлүүлж байлаа.

Төлөөлөгчид үүгээрээ Христэд итгэгчдийн урам зоригийг хугалахыг хүсээгүй юм шүү. Харин ч тэд Сүмийг бэрхшээл саадтай тулгарахдаа Христэд итгэж, Ариун Сүнсний хайр өршөөл болон бэлэг авъяаст найдаж, Ертөнцийн Эзэний ажлыг тууштай үргэлжлүүлэхэд бэлтгэх санаатай байжээ.

Ийнхүү Төлөөлөгчид сүмийг өөрсдийн гэрчлэл болон сургаалаар үндэслэн байгуулж, тэнд ажиллах албан тушаалтануудыг томилж, бэрхшээл саад болон өөр олон зүйлтэй тулгарахад бэлтгэлээ. Ингэснээрээ тэд Сүм Ертөнцийн Эзэний ер бусын хаант улсыг өргөжүүлэх ажлыг улс орон бүрт, шинэ үе бүрт биелүүлэх боломжтой болгож байна.

ДҮГНЭЛТ

Энэ хичээлээр бид Үйл явдал номонд сүлжилдэн орсон гурван гол сэдвийг үзлээ. Бид Ариун Сүнсний ажил хэрэг ба авьяас чадварын тухай үзсэн. Бид Христийн цорын ганц эрх мэдэлтэй гэрч болсон Төлөөлөгчдийн ач холбогдлын талаар ярилцсан. Мөн бид Төлөөлөгчид хэрхэн Сүм байгуулж оногдсон үүрэг даалгавраа биелүүлж байгаа талаар үзлээ.

Үйл явдал ном нь түүх болон теологийн талаар өгүүлсэн гайхалтай бүтээл юм. Луух үүнийг Тёфил болон эхэн үеийн итгэгчдэд хандан бичихдээ, Ертөнцийн Эзэний ер бусын хаант улсын тухай сайн мэдээг Ариун Сүнсний хүч чадлаар энэ дэлхийн улс үндэстнүүдэд гэрчлэн ярьж тараах нь ямар чухал болохыг онцолсон байна. Өнөө үед бид яг энэ хичээлийг амьдралдаа хэрэгжүүлэхдээ, мөн адил Ертөнцийн Эзэний хаант улсыг өргөжүүлэн тэлэхэд өөрсдийгөө зориулж, Христ эргэж ирээд мөнхийн улсаа бүрэн гүйцэд байгуулах тэр өдрийг ч гэсэн тэсэн ядан хүлээх хэрэгтэй.

Др. Ханс Ф. Байер (Host) is Professor of New Testament and Chair of the New Testament Department at Covenant Theological Seminary in St. Louis, Missouri. Dr. Bayer received his M.A. and M.Div. from Ashland Theological Seminary, and his Ph.D. from University of Aberdeen in Scotland. Born and raised in Germany, Dr. Bayer taught for ten years at the German Theological Seminary at Giessen, where he also planted and co-pastored a church. He lectures and preaches regularly throughout the U.S. and Europe and has published numerous English and German monographs, essays, dictionary articles, and commentaries, primarily on the Gospels and the Book of Acts. He is also the author of *A Theology of Mark: The Dynamic Between Christology and Authentic Discipleship* (P&R, 2012).

ТАЙЛБАР ТОЛЬ

Төлөөлөгч (элч) – Шинэ Гэрээн дээрх онцгой албан тушаал. Тэд Есүсээр биечлэн бэлтгэгдсэн, Түүнийг үхлээс амилсан байгааг нь нүдээрээ харсан, мөн Их Эзэн Есүс өөрөө томилсон хүмүүс. Грекийн “илгээгдсэн хүн” гэсэн утгатай үг

apostolos – “илгээгдсэн хүн” гэсэн утгатай (үгчилэн орчуулга) Грек үг

Гамаалиел – Фарисей бүлгийн гишүүн, олонд хүндлэгдсэн Еврейн багш. Санхедрины өмнө элч нарыг өмгөөлөн үг хэлж байсан бөгөөд тодорхой хугацаанд элч Пуулийн багш нь байсан

Яахооб (төлөөлөгч) – Зебедийгийн хүү, Иоханы ах, Хэрэд Агрип хаанд цаазлуулсан

Яахооб (Есүсийн дүү) – Есүсийн эх Мариас төрсөн дүү. Иерусалимийн Христэд итгэгчдийн сүмийн ахлагч, Шинэ Гэрээний Яахооб номыг бичсэн

Иеремиа – Хуучин Гэрээний зөнч (эш үзүүлэгч) МЭӨ 626-586 хооронд амьдарч байсан. “Уйлдаг эш үзүүлэгч” гэдэг хочтой. Иудейгийн ирээдүйн тухай болон шинэ гэрээний тухай зөгнөсөн

Иоел – Израилчуудыг Вавилон руу туугдах үед амьдарч үйлчилж байсан зөнч (эш үзүүлэгч), цөллөгийн дараа сэргэлт ирэх болно гэж найдвар түгээж байсан. Ариун Сүнс цутган буух болно гэж зөгнөсөн. Пэтр энэ зөгнөлийг нь Үйл явдал номын 2-р бүлэг дээр Пэнтээхөст баярын өдөр эш татсан байдаг

Матиас – 11 төлөөлөгч (элч нар) Хариот хотын Иудасын оронд энэ хүнийг төлөөлөгчөөр (элч) сонгон томилсон

Пэнтээхөст – Еврей баяр. “долоо хоногуудын зоог” гэж нэрлэгддэг. эхний ургацаа авсны тэмдэглэлт өдрүүд бөгөөд Христэд итгэгчдийн хувьд Ариун Сүнс анхны сүмийнхэн дээр буусан өдөр юм

Петр – Есүсийн арван хоёр төлөөлөгчдийн нэг, Симон ч гэж дуудаг. Анхны сүмийн удирдагчдын нэг. Үйл явдал номын 2-р бүлэгт Пэнтээхөст баяраар олны өмнө номлосон хүн. Марк Петрийн ярьсан зүйл дээр үндэслэн Сайн мэдээний Марк номоо бичсэн гэж түүхчид үздэг

Руах Элохим – “Ертөнцийн Эзэний Сүнс” гэсэн утгатай Еврей үг

Туран – Эфэс хотод Хурлын танхим эзэмшдэг хүн. Энэ хурлын танхимд олон шинэ содон санаанууд яригддаг байсан бөгөөд Пууль энд сайнмэдээг тунхагласан байдаг